

# ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ





# ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Судлаач: Г.ХАЛИУНАА  
Б.АРИУНЖАРГАЛ

Улаанбаатар хот  
2021 он

ННА 67.408  
ДАА 345  
Х-194



## **ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Судлаач:  
Г.Халиунаа, Б.Ариунжаргал

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд  
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9812-3-5

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамъян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: 976-76113207  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад өрнөж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд асуудал дагуулсан зохицуулалтын нэг нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа юм. Тухайлбал, 2015 оны Эрүүгийн хуулиар зөвхөн хорих, зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой хуульчилсны улмаас тодорхой төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй, тодорхойгүй байдал бий болгосон билээ. Мөн хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох уу эсхүл яллагдагчаар татах хүртэл тоолох уу гэдэг асуудал ч эргэлзээ дагуулсан юм. 2020 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль эдгээр зөрчилтэй асуудлын заримыг зохицуулаад байна.

Гэсэн хэдий ч энэ чиглэлээр гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ шаардлага байсаар байгааг харгалзан үзэж “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: Тулгамдаж буй асуудал” сэдэвт судалгаа хийж олон нийтэд хүргэж байна. Судлаач Г.Халиунаа, Б.Ариунжаргал нар Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны тухай ойлголт хэрхэн зохицуулагдаж ирснийг түүхчлэн судлахын зэрэгцээ эх газрын болон холимог эрүүгийн эрх зүйн системээс тодорхой улсыг сонгон харьцуулан судалсан юм. Үүний зэрэгцээ хуулийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж буйг судалж, зарим төрлийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой онцлог зохицуулалтыг авч үзсэн болно.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд эдүгээ 30 орчим судалгаа олны хүртээл болоод байна. Мөн бид дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлэг эхлүүлээд байгаа бөгөөд хэлэлцүүлгийн дүрс бичлэгийг манай байгууллагын цахим хуудас, нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

# АГУУЛГА

|                                                                                                                                     |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| ӨМНӨХ ҮГ .....                                                                                                                      | 3  |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....                                                                                                      | 6  |
| УДИРТГАЛ .....                                                                                                                      | 7  |
| НЭГ. ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ<br>ОНОЛЫН ОЙЛГОЛТ, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ .....                                                  | 12 |
| 1.1 Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны<br>онолын асуудал .....                                                                    | 12 |
| 1.2 Шинэ болон нэн шинэ үеийн эрүүгийн эрх зүйд<br>гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг<br>хуульчилсан байдал, түүхэн уламжлал ..... | 16 |
| Нэгдүгээр бүлгийн дүгнэлт .....                                                                                                     | 34 |
| ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД<br>ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТАЛААР<br>ТУСГАСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА .....          | 36 |
| 2.1. Эх газрын (Ром-Германы) эрүүгийн эрх зүйн систем .....                                                                         | 36 |
| 2.1.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс .....                                                                                     | 37 |
| 2.1.2. Бүгд Найрамдах Солонгос Улс .....                                                                                            | 40 |
| 2.2. Холимог эрүүгийн эрх зүйн систем .....                                                                                         | 41 |
| 2.2.1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс .....                                                                                           | 41 |
| 2.2.2. Оросын Холбооны Улс .....                                                                                                    | 43 |
| Хоёрдугаар бүлгийн дүгнэлт .....                                                                                                    | 45 |

|                                                                                                                                           |     |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААТАЙ<br>ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ,<br>ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ ..... | 46  |
| 3.1 Прокурорын байгууллагын статистик мэдээлэлд<br>үндэслэсэн дүн шинжилгээ .....                                                         | 46  |
| 3.2 Шүүхийн шийдвэрийн статистик мэдээлэлд<br>үндэслэсэн дүн шинжилгээ .....                                                              | 49  |
| 3.3 Эрх зүйн хийдэл, тулгамдсан асуудал .....                                                                                             | 53  |
| Гуравдугаар бүлгийн дүгнэлт .....                                                                                                         | 74  |
| ДӨРӨВ. ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГТ<br>ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ЯЛГАМЖТАЙ БАЙДЛААР<br>ЗОХИЦУУЛАХЫН УЧИР ХОЛБОГДОЛ .....                        | 76  |
| 4.1 Олон улсын баримт бичиг ба Монгол Улсын<br>хууль тогтоомж .....                                                                       | 76  |
| 4.2 Хөөн хэлэлцэх хугацааг нь ялгамжтай байдлаар<br>зохицуулах шаардлагатай гэмт хэргүүд .....                                            | 79  |
| Дөрөвдүгээр бүлгийн дүгнэлт .....                                                                                                         | 90  |
| НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....                                                                                                                     | 92  |
| НОМ ЗҮЙ .....                                                                                                                             | 98  |
| ХАВСРАЛТ .....                                                                                                                            | 102 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|        |                                             |
|--------|---------------------------------------------|
| АИХ    | Ардын Их Хурал                              |
| АНУ    | Америкийн Нэгдсэн Улс                       |
| БНМАУ  | Бүгд Найрамдах Монгол Ард Улс               |
| БНСУ   | Бүгд Найрамдах Солонгос Улс                 |
| БНХАУ  | Бүгд Найрамдах Хятад Ард Улс                |
| МУҮХ   | Монгол Улсын Үндсэн хууль                   |
| НҮБ    | Нэгдсэн Үндэстний Байгууллага               |
| ОХУ    | Оросын Холбооны Улс                         |
| УИХ    | Улсын Их Хурал                              |
| ХБНГУ  | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс          |
| ЭХЕА   | Эрүүгийн хуулийн ерөнхий анги               |
| ЭХХШтХ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль |

# УДИРТГАЛ

## 1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Эрүүгийн хуулийн зорилго нь хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Энэ ч утгаараа эрүүгийн хариуцлага нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хариуцлагын хэлбэр билээ. Хүн бүр тэгш эрхтэй ч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрхийг хуулиар хязгаарлах нь зүйн хэрэг. Нөгөөтээгүүр хүний эрх, эрх чөлөөг хамгийн ихээр хязгаарладгийнхаа хувьд Эрүүгийн хууль эрх зүйн хэм хэмжээний хийдэлтэй байвал нийгэмд сөрөг үр дагавар үүсгэж, хүний эрхийг хязгаарлах гол хэрэглүүр болж хувирахыг ч үгүйсгэх аргагүй.<sup>1</sup>

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсноос хойш дөрвөн жил орчим болж байна. Хэдийгээр энэ хугацаанд хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн ажлууд хийгдэж байгаа ч практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт цөөнгүй байна. Тэдгээрийн нэг нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа”-ны талаарх зохицуулалт юм. Тухайлбал, тус зүйлд заасан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэг болон хорих, зорчих эрхийг хязгаарлах ялтай зарим гэмт хэрэгт<sup>2</sup> хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь тодорхойгүй байна.

<sup>1</sup> Г.Халиунаа, Б.Ариунжаргал (2019), Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хүний эрхийг зөрчих нь, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №1, 54-61 дэх тал.

<sup>2</sup> Тус зохицуулалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан ч өнөөдрийг хүртэл практикт хэрэгжүүлэхэд маргаан дагуулахаар заалтууд байсаар байна.



Түүнчлэн ЭХХШтХ-д заасан гэмт хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлд “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан”<sup>3</sup> гэх үндэслэл багтдаг билээ. Энэ нь тус зохицуулалтын ач холбогдлыг шууд илэрхийлж буй заалтуудын нэг юм. Гэтэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт эрх зүйн хийдэлтэй хуульчлагдсан нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээд ял завших боломж бүрдүүлж байна. Цаашлаад тус зохицуулалт эрх зүйн хийдэлтэй байх нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг, ялын бодлого, хуулийн зохицуулалтын уялдаа холбоо, эрх зүйн зарчим, хуулийн зорилго алдагдахад хүрэх эрсдэлтэй. Иймд энэхүү зохицуулалтыг судалж үзэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн болно.

## 2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны зорилго нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын ач холбогдол, онцлог, эл ойлголтын түүхэн уламжлал, гадаадын зарим оронд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар хуульчилсан байдлыг харьцуулан судлах, уг зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, эрх зүйн хийдэл, цаашид боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсын Эрүүгийн хуулийн түүхэн уламжлалыг судлан, үе үеийн Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчлан зохицуулж ирснийг түүхчлэн судлах;
- Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх эрх зүйн зохицуулалт, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг судлах, практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх;

<sup>3</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5, 34.19 дүгээр зүйлд тус тус хуульчилсан.

- Гадаадын зарим оронд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан талаар харьцуулан судлах;
- Зарим төрлийн гэмт хэрэгт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай зохицуулахын ач холбогдлыг судлах;
- Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга зам эрэлхийлж, судалгааны үр дүнд үндэслэн дүгнэлт өгч, санал дэвшүүлэх зэрэг болно.

### 3. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалт Эрүүгийн хуульд хуульчлагдсан үеэс өнөөдрийг хүртэл улс орны хөгжил, нийгмийн өөрчлөлттэй уялдан хувьсан өөрчлөгдөж, боловсронгуй болсоор ирсэн. Өмнөх Эрүүгийн хуулиудад тусгагдсан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тухайн цаг үед нь тус салбарын эрдэмтэн, судлаачид онол, практикийн үүднээс судлан бүтээл, судалгааны ажилдаа тусгасаар ирсэн. Тухайлбал, академич С.Нарангэрэлийн “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” ерөнхий анги<sup>4</sup>, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совдын “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс”<sup>5</sup>, мөн түүний “Эрүүгийн хариуцлага: уламжлал, шинэчлэлийн асуудал” хууль зүйн докторын зэрэг горилж бичсэн бүтээл<sup>6</sup>, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцангийн “Гэмт хэргийн олонлог”<sup>7</sup>, “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” альбом-схем<sup>8</sup>, Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган нарын “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн удиртгал”<sup>9</sup>, Г.Гантөмөр, О.Амарсайхан нарын “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа”<sup>10</sup> зэрэг бүтээлүүдийг дурдаж болох юм. Ялангуяа хууль зүйн

<sup>4</sup> С.Нарангэрэл (1997), Монгол Улсын эрүүгийн эрх зүй, ерөнхий анги

<sup>5</sup> Г.Совд (1973), БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс

<sup>6</sup> Г.Совд (1992), Эрүүгийн хариуцлага: уламжлал, шинэчлэлийн асуудал-хууль зүйн докторын зэрэг горилж бичсэн диссертац

<sup>7</sup> С.Жанцан (1990), Гэмт хэргийн олонлог

<sup>8</sup> С.Жанцан (1991), Монгол Улсын эрүүгийн эрх зүй-альбом-схем

<sup>9</sup> Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүйн удиртгал

<sup>10</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа

шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан өөрийн бүтээлд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн олонлогийг үгүйсгэх нөхцөл байдал болох талаас нь, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үндэслэл болох талаас нь судлан үзсэн байдаг бол Г.Гантөмөр, О.Амарсайхан нар эрүүгийн эрх зүйн хугацаа, түүний төрлийг авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн үйлчлэх цаг хугацаа, гэмт хэрэг үйлдсэн цаг, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй болон шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа, ялгүй болох хугацааны талаар дэлгэрэнгүй судалж, эдгээрийн түүхэн уламжлал, ойлголт, мөн чанар, эрүүгийн эрх зүйн учир холбогдлыг анх удаа иж бүрнээр нь авч үзэн, нэг сэдэвт бүтээл болгосон байна.

Мөн 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тус салбарын эрдэмтэн, судлаачид авч үзэн бүтээлдээ дурдаж, цөөнгүй өгүүлэл, нийтлэл, илтгэл хэлэлцүүлжээ. Тухайлбал, доктор Ц.Цэлмэгийн “Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны учир холбогдол”, доктор Д.Зүмбэрэллхамын “Хөөн хэлэлцэх хугацаа ба ял завшуулах ажиллагаа”, доктор Х.Эрдэм-Ундрахын “84 гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь тодорхойгүй байна” зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, ярилцлага байгаагаас гадна энэхүү судалгааг гүйцэтгэсэн судалгааны багийн гишүүдийн бичиж, нийтлүүлсэн эрдэм шинжилгээний хэд хэдэн өгүүлэл, илтгэл байна. Тухайлбал, Г.Халиунаа, Б.Ариунжаргал нарын “Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хүний эрхийг зөрчих нь”, “Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт”, “*Statute of Limitations Regulation in the Criminal Law in Mongolia*” гэх зэргийг дурдаж болох юм.

#### 4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ХАМРАХ ХҮРЭЭ

Уг судалгааг шинжлэх ухааны судалгааны арга зүйд тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд чингэхдээ 1926, 1929, 1934 оны Шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг хэрхэн тусгаж ирснийг түүхчлэн авч үзэж, тэдгээрийг 2015 оны Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалттай

харьцуулан судаллаа. Түүнчлэн гадаадын зарим орны тухайлбал, эх газрын эрх зүйн системтэй улс орноос ХБНГУ, БНСУ, холимог эрх зүйн системийн орноос ОХУ, БНХАУ-ыг сонгон авч эдгээр орон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг хэрхэн хуульчилсныг мөн авч үзлээ. Мөн эдгээр орны зохицуулалтыг өөрийн орны Эрүүгийн хуультай харьцуулан авч үзсэнээс гадна 2015 оны Эрүүгийн хууль, тус хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилт, уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд холбогдох эх сурвалж, баримт мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

# НЭГ. ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ОНОЛЫН ОЙЛГОЛТ, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

## 1.1. ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ОНОЛЫН АСУУДАЛ

Дэлхийн ихэнх улсад гэмт хэрэгтэнд хариуцлага хүлээлгэж болох тодорхой хугацааг Эрүүгийн хуулиар эсхүл тусгайлсан хуулиар зохицуулсан байдаг. Энэ нь гэмт хэрэг үйлдсэнээсээ хойш тухайн гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө хуульд заасан хариуцлага хүлээхээс зориуд зайлсхийх үйлдэл хийгээгүй, түүнээс хойш хуульд тусгайлан заасан хугацааны дотор дахин ямар нэгэн гэмт хэрэг үйлдээгүй нь нотлогдвол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн ойлголт юм. Нөгөө талаас уг гэмт хэргийг илрүүлэн шийтгэх арга хэмжээг тухайн хугацаанд нь амжиж авч чадаагүйн төлөө төрийн хүлээх хариуцлагын хэлбэр гэж тайлбарлах нь ч бий. Аль ч онолын үзэл баримтлалаас авч үзсэн гэмт хэргийг “хөөн хэлэлцэх хугацаа” гэх ойлголтыг гэмт этгээдийг ял завшуулах хэрэгсэл болгож болохгүй гэсэн үзэл санаа давхар агуулагдаж явдаг. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн л бол ял шийтгэл гарцаагүй байх тухай дэлхий даяар түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн зарчимтай холбоотой.<sup>11</sup>

Үг зүйн хувьд “хугацаа” гэдэг нь цаг зайны хэмжээг<sup>12</sup> илэрхийлсэн утга юм. Харин эрүүгийн эрх зүйд хугацаа нь ямар агуулга, хэм хэмжээтэй холбогдон яригдаж байна вэ гэдгээс хамаарч:

<sup>11</sup> Д.Зүмбэрэллхам (2019), Хөөн хэлэлцэх хугацаа ба ял завшуулах ажиллагаа, ярилцлага.  
<http://itoim.mn/article/iLAEP/17846?fbclid=IwAR0fXy8X4kG6TxaOwKyEmOtUwEy0r983idkVaDytvzhdiCcl5L5Aj76pY8>

<sup>12</sup> Я.Цэвэл (1966), Монгол хэлний товч тайлбар толь, 640 дэх тал.

- Эрүүгийн хуулийн үйлчлэх хугацаа;
- Гэмт хэрэг үйлдсэн цаг;
- Хөөн хэлэлцэх хугацаа;
- Ялын хугацаа гэх мэт ойлголтыг илэрхийлдэг.

Эрүүгийн хуулийн үйлчлэх хугацаа нь тухайн хуулийн үйлчлэх, мөрдөгдөх хугацааны тухай асуудал байдаг бол гэмт хэрэг үйлдсэн цаг нь хууль тогтоогчоос Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйлийн диспозицид тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд урьдчилан заасан цагийг ойлгодог.<sup>13</sup> Харин гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны тухайд нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүнд хуульд заасан тодорхой хугацааны дотор эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний дараа уг хэрэгт хариуцлага хүлээлгэх эрх зүйн ач холбогдол бага, тухайн гэмт хэргийн нийгэмд аюултай шинж арилсан байдаг зэргийг харгалзан үзэх хугацаа байдаг. Тэгвэл ялын хугацаа нь зөвхөн эрүүгийн ялтай холбоотой яригдах бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг ямар хугацаанд эдлүүлэхийг илэрхийлдэг.

Хөөн хэлэлцэх хугацааг утга, агуулгын хувьд эрдэмтэн, судлаачид бүтээлдээ дараах байдлаар тайлбарласан байна. Тухайлбал, академич Ж.Амарсанаа нарын “Хууль зүйн тайлбар толь” бүтээлд “...эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааг хуульд заасан тодорхой хугацаа өнгөрч хуулиар тодорхойлсон нөхцөл байдал бий болсон нөхцөлд эрүүгийн хариуцлага буюу шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үгүйсгэгдэх нөхцөл байдал”<sup>14</sup> гэж, академич С.Нарангэрэл “Монголын эрх зүйн эх толь бичиг” бүтээлдээ “хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн эрх зүйд эрүүгийн эрх зүйн институтын нэг, хэрэв шүүн таслах ажиллагаанаас зайлсхийгээгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хугацаа”<sup>15</sup> гэж тайлбарлажээ. Мөн хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд “Эрүүгийн хуулийн тайлбар” бүтээлдээ “гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй (хөөн хэлэлцэх) хугацааг хуульчилсан явдал бол гэмт хэрэг үйлдсэнээс хойш уг этгээдийг

<sup>13</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 52 дахь тал.

<sup>14</sup> Ж.Амарсанаа нар (2003), Хууль зүйн тайлбар толь, 309 дэх тал.

<sup>15</sup> С.Нарангэрэл (2015), Монголын эрх зүйн эх толь бичиг, 516 дахь тал.

илрүүлж, эрүүгийн хариуцлагад таталгүй урт хугацаа өнгөрсний дараа хуульд заасан болзол бүрдсэн нөхцөлд хэрэг хуучирсан буюу хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэх нь хууль ёсны үндэслэл юм. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш илрэхгүй хуульд заасан хугацаа өнгөрч гэмт хэрэг хуучирсан тохиолдолд эрүүгийн хариуцлагад татаж болдоггүйн шалтгаан гэвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ямар ч зорилгогүй болсон байдаг”<sup>16</sup> гэжээ. Мөн хөөн хэлэлцэх хугацаа гэдэгт үйлдсэн хэргийн ангилал болон оногдуулах ялыг шалгуур болгон эрүүгийн хариуцлагад татаж болох хугацааг ойлгох бөгөөд энэ нь хугацаа зогсох, тасрах зэрэг ойлголтуудыг өөртөө багтаана. Хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагад татах эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ойлголт гэсэн байна.<sup>17</sup> Түүнчлэн доктор Г.Гантөмөр нарын “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа” бүтээлд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг “Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь үйлдэгдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан, хийсэн гэмт хэргийн ангилал, шийтгэсэн ялын төрөл, хугацаагаар харгалзан ялгамжтай тогтоосон эрүүгийн хуулийн 72, 76 дугаар зүйлд заасан, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болох хугацааг хэлнэ”<sup>18</sup> гэж 2002 оны Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагад татаж болохгүй болон шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг тодорхойлж байжээ.

Хөөн хэлэлцэх хугацаа нь зөвхөн эрүүгийн эрх зүйн ойлголт биш бөгөөд бусад салбар эрх зүйд ч мөн уг хугацааны нийтлэг болон ялгаатай шинж агуулагдаж байдаг. Тухайлбал, иргэний эрх зүйд хөөн хэлэлцэх хугацааг<sup>19</sup> иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдоос эрх, үүргээ зөрчсөн тохиолдолд зохих этгээдээс өөрийн зөрчигдсөн буюу маргаж буй эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүх, арбитрын байгууллагад мэдүүлж болох (нэхэмжлэл гаргах) хугацаа байдаг<sup>20</sup> бол

<sup>16</sup> Г.Совд (1982), Эрүүгийн хуулийн тайлбар.

<sup>17</sup> Мөн тэнд.

<sup>18</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 60 дахь тал.

<sup>19</sup> Иргэний хууль (2002), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, №7, 74-82 дугаар зүйл.

<sup>20</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 61 дэх тал.

захиргааны эрх зүйн хөөн хэлэлцэх хугацаа<sup>21</sup> нь захиргааны актыг хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш гомдлоо хянан шийдвэрлэх байгууллагад гаргах хугацааг ойлгодог. Харин эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг, эрүүгийн хариуцлага, ялтай холбогддог.

Онолын хувьд хөөн хэлэлцэх хугацааны тухай эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа, шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа гэсэн хоёр ойлголт бий.<sup>22</sup> Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг тайлбарлавал, гэмт хэрэг илэрсэн ч хэрэгтэн баригдаагүй байх, баригдсан ч тодорхой шалтгааны улмаас хэрэг шалган шийдвэрлэгдэхгүй явсаар хуульд заасан тодорхой хугацаа өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр тухайн хэргийг хаадаг. Харин шүүхийн таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг тайлбарлавал, гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд шүүхээс ял шийтгэл оногдуулах бөгөөд уг шүүхийн шийдвэр хуульд заасан тодорхой хугацаанд биелэгдээгүй байхыг ойлгоно. Энэ нь гэхдээ зөвхөн ялтны хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас шалтгаалсан байх ёстой<sup>23</sup> байдаг.

Энэ талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд “Эрүүгийн хуулийн тайлбар” бүтээлдээ “Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэл нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдог. Хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа нь тодорхой цаг хугацааны хувьд гэмт этгээд засарч, төлөвшсөн, учруулсан гэм хор нь нийгмийн ач холбогдлоо алдсан гэх мэт олон зүйлээс хамаардаг боловч нөгөө талаараа гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завших боломжийг олгож байдаг зохицуулалт юм. Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн бүрдэл төгссөн үеэс эхлэн тоолно. Учир нь гэмт хэргийн бүрдэл төгсөх, гэмт хэргийн

<sup>21</sup> Захиргааны ерөнхий хууль (2015), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, №28, 94 дүгээр зүйл.

<sup>22</sup> Х.Эрдэм-Ундрах (2019), 84 гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь тодорхойгүй байна, ярилцлага.  
<https://newspress.mn/v1/p/news/10206>

<sup>23</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 112 дахь тал.



хор уршиг үгүй болох хоёр нэг зэрэг байдаггүй”<sup>24</sup> гэж тэмдэглэсэн байдаг.

2002 оны Эрүүгийн хуулийн 9 дүгээр зүйлд заасан Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг 2015 оны Эрүүгийн хуулиар 1.2 дугаар зүйлд заасан Хууль ёсны зарчмын агуулгад нэгтгэн хуульчилсан. Хууль ёсны зарчмын үүднээс эрүүгийн хариуцлага гарцаагүй байх ёстой ч хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд шударга ёсны зарчмыг удирдлага болгон гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа нь хууль зүйн үндэслэлтэй юм.

## 1.2. ШИНЭ БОЛОН НЭН ШИНЭ ҮЕИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙД ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Энэхүү судалгааны хүрээнд 1920-иод оноос хойш өнөөг хүртэлх төрөлжсөн Эрүүгийн хуулиудад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчлан дагаж мөрдөж байсныг судлан үзлээ.

Монгол Улс Эрүүгийн хуулийг анх 1926 онд “Шүүх цаазын бичиг” хэмээх нэртэйгээр баталж байжээ.<sup>25</sup> Үүний дараа 1929, 1934 онд “Шүүх цаазын бичиг” нэртэйгээр батлан мөрдөж байсан бөгөөд 1942 оноос Эрүүгийн хууль хэмээн нэрийджээ. Гэсэн хэдий ч дээрх хуулиудад “хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн нэр томьёо байгаагүй бөгөөд анх 1961 оны Эрүүгийн хуульд энэхүү нэр томьёог хуульчилсан байна.

“БНМАУ-ын шүүх цаазын бичиг” (цаашид “Шүүх цаазын бичиг” гэх) 1926 он

Шүүх цаазын бичиг нь ерөнхий, тусгай ангиас бүрдэх бөгөөд ерөнхий анги нь долоон бүлэг, 40 зүйлтэй, тусгай анги нь 24 бүлэг, 187 зүйлтэй батлагджээ. Тус хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар дараах байдлаар хуульчилсан байна.

<sup>24</sup> Г.Совд (1982), Эрүүгийн хуулийн тайлбар.

<sup>25</sup> Тус хуулийг баталснаас хойш 1929, 1934, 1942, 1961, 1987, 2002, 2015 онд шинэчилж байжээ.

Шүүх цаазын бичгийн “Ялыг хорогдуулах ба хөнгөтгөх нь” хэмээх тавдугаар бүлгийн 28 дугаар зүйлд “Аливаа гэмт явдал үйлдсэн хүн мэдэгдсэн үгүй явсаар дор заасан хугацааны дотор гэм (тийм гэмт явдал) үл гаргаваас ялыг үл хэлэлцэнэ. Үүнд ялыг хүнд, хөнгөнд дагалдуулж (тааруулж) анхны гэмт явдал үйлдсэн өдрөөс бодож тогтоосон хугацаа нь:<sup>26</sup>

1. Алах ял бүхий хэрэг дор 12 жил;
2. 8-10 жил хүртэл гянданд хоригдох ял бүхий хэрэгт 9-11 жил;
3. 5-7 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэгт 6-8 жил;
4. 2-4 жил хоригдох ял бүхий хэрэгт 3-5 жил;
5. 1 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэгт 2 жил болно” хэмээжээ.

Уг Шүүх цаазын бичигт хөөн хэлэлцэх хугацааны зөвхөн нэг төрлийг өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны талаар заасан бөгөөд нөгөө төрөл болох таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг тоолох журмыг хуульчлаагүй байна.

“БНМАУ-ын шүүх цаазын бичиг” 1929 он

Шүүх цаазын бичиг нь ерөнхий, тусгай ангиас бүрдэх бөгөөд ерөнхий анги нь зургаан бүлэг, 41 зүйлтэй, тусгай анги нь 24 бүлэг, 186 зүйлтэй батлагджээ. Тус хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар “Ял үл хэлэлцэх нь” хэмээх гуравдугаар бүлгийн 24 дүгээр зүйлд:

“Аливаа гэмт явдал үйлдсэн хүмүүн мэдэгдээгүй явсаар дор дурдсан хугацааны дотор дахин гэм гаргаагүй аваас ял үл хэлэлцмөй. Үүнд ялын хүнд, хөнгөнд тооцоолж анх гэмт хэрэг үйлдсэн өдрөөс бодож тогтоосон хугацаа нь:<sup>27</sup>

1. Буудан алах ял бүхий хэрэг дор 12 жил;
2. 8-10 жил хоригдох ял бүхий хэрэг дор 9-11 жил;

<sup>26</sup> Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 285 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

<sup>27</sup> Мөн тэнд, 315 дахь тал.

3. 5-7 жил хоригдох ял бүхий хэрэг дор 6-8 жил;
4. 2-4 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэг дор 3-5 жил;
5. 1 жил хүртэл хоригдох ял бүхий хэрэг дор 2 жил” гэж тусгажээ.

Тус хуульд 1926 оны Шүүх цаазын бичигт зааснаас ямар нэг өөрчлөлтгүйгээр хуульчлагдсан ба таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацааг мөн адил тогтоогоогүй байна.

“БНМАУ-ын шүүх цаазын бичиг” 1934 он

Шүүх цаазын бичиг нь ерөнхий, тусгай ангиас бүрдэх бөгөөд 14 бүлэг, 154 зүйлтэй батлагджээ. Тус хууль нь Шүүх цаазын бичгийн зорилтыг тодорхойлж, гэмт хэргийн тодорхойлолтыг өгч (гэмт хэргийг нийгэмд учруулах хор аюул талаас нь голлон тодорхойлсон), ял шийтгэлийн зорилго, гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай үндсэн салбар заалтыг нарийн дэс дараалалтай тогтоосон зэргээрээ ялгагдах онцлогтой юм. Тус хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг “Шүүх цаазын бодлогын ерөнхий үүсэл” хэмээх 3 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилжээ.

“Шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болох шалтгаануудад:<sup>28</sup>

1. Гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэхүү хэргийн тухайд шүүн таслах газраас нэгэн жил хүртэл хорих буюу өөр хөнгөн ял шийтгэх агсан боловч гурван жил өнгөрвөл;
2. Шүүн таслах газраас нэгэн жилээс дээш боловч таван жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэх агсан бөгөөд уул гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш таван жил хүртэл өнгөрвөл;
3. Шүүн таслах газраас таван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэх агсан боловч нэгэнт уул гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн бол шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болно. Хэрвээ дээр заасан хугацааны дотор гэмт хэрэг үйлдэгчээс дахин урьд лугаа нэгэн төрлийн буюу нэгэн мөн түүнээс хөнгөн бус гэмт хэрэг үйлдвээс удсаны хугацааг хоёрдугаар удаагийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолмой” гэжээ.

<sup>28</sup> Мөн тэнд, 346 дахь тал.

Мөн бүлгийн 9 дүгээр зүйлд<sup>29</sup> “Шүүн таслах газрын таслан шийтгэсэн тогтоол нь уул шийтгэн гаргасан өдрөөс эхлэн 10 жилийн дотор, хэрэв гүйцэтгэсэн үгүй аваас гүйцэтгэх явдал үгүй болмой” хэмээн тус тус хуульчлан тогтоожээ.

Тус хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулж болох ялын байдалтай нь харьцуулан 3-10 жил (дээд, доод хязгаар) байхаар нарийвчлан тогтоожээ. Өөрөөр хэлбэл, өмнөх Шүүх цаазын бичгүүдтэй харьцуулахад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааны доод хязгаар нь нэг жилээр нэмэгдэж, дээд хязгаар нь хоёр жилээр багассан байна.<sup>30</sup>

### “БНМАУ-ын Эрүүгийн хууль” 1942 он

БНМАУ-ын VII Их Хурал 1940 оны зургадугаар сард хуралдан БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг баталсан. Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд “БНМАУ болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм, журамд дэвшин орох учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүх хөдөлмөрчин (малчин, ажилчин, оюутан) ардын тусгаар тогтносон улс мөн болно” гэж тус улсын шинж байдлыг тодорхойлжээ.<sup>31</sup> Ийнхүү батлагдсан Үндсэн хуулийнхаа зарчимд нийцүүлэн бусад салбар эрх зүйн актыг шинээр батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагын хүрээнд 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр хуралдсан Улсын 25 дугаар Бага Хурлаар Шүүх цаазын бичгийг Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа “БНМАУ-ын Эрүүгийн хууль” нэртэйгээр батлан гаргасан байна. Тус хууль нь ерөнхий, тусгай ангиас бүрдэх бөгөөд 16 бүлэг, 219 зүйлтэй батлагджээ. Хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг уг хуулийн 3 дугаар бүлгийн 13 дугаар зүйлд дараах байдлаар тусгажээ.

<sup>29</sup> Мөн тэнд.

<sup>30</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 79 дэх тал.

<sup>31</sup> Ж.Амарсанаа, О.Батсайхан (2004), Монгол Улсын Үндсэн хууль: Баримт бичиг, 1924, 1940, 1960, 1992.

“Эрүүгийн хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох шалтгаанууд нь.”<sup>32</sup>

1. Гэмт хэрэг үйлдсэн бөгөөд энэхүү хэрэгт шүүх таслах газраас нэгэн жил хүртэл хорих буюу өөр хөнгөн ял шийтгэх байсан боловч гурван жил өнгөрсөн байвал;
2. Шүүх таслах газраас нэгэн жилээс дээш, таван жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих ял шийтгэх байсан боловч уул гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн байвал;
3. Шүүх таслах газраас 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэх байсан боловч нэгэнт уул гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн байвал тус тус хөөн шийтгэж үл болно.

Хэрэв дурдсан хугацаанд уул үйлдсэн гэмт хэрэг нь мөрдөн байцаах буюу шүүх таслах газар мэдэгдээгүй байвал он удаж мэдэгдээгүй хэрэгт үзэж он улирсан явдлыг хэрэглэнэ. Ийнхүү удах завсар уул үйлдсэн гэмт хэрэг нь мөрдөн байцаах газар мэдэгдэх буюу мөн энэ хугацааны дотор уул хүн дахин нэг төрлийн буюу өөр хөнгөн бус гэмт хэрэг өдүүлбэл он удсаны хугацааг хоёр дугаар удаагийн гэмт хэрэг өдүүлсэн өдрөөс эхлэн тоолно.

Тайлбарлах нь: Хувьсгалын эсэргүү гэмт хэргийн учир эрүүгийн хариуцлагад татагдах болбол он удаж улирсан явдлыг үл хэрэглэнэ.”

Мөн бүлгийн 14 дүгээр зүйлд:<sup>33</sup> “Шүүн таслах газрын таслан шийтгэсэн тогтоол нь уул шийтгэн гарсан өдрөөс эхлэн арван жилийн дотор гүйцэтгэгдээгүй байвал гүйцэтгэх явдалгүй болно” гэж хөөн хэлэлцэх хугацааны 2 төрлийг тус тус хуульчилжээ.

1942 оны Эрүүгийн хуульд заасан дээрх зохицуулалт нь 1934 оны Шүүх цаазын бичгийн заалттай харьцуулахад зарчмын хувьд ялгаагүй. Харин шинэ Эрүүгийн хуулиар хувьсгалын эсэргүү гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхийг хориглосон заалтыг шинээр нэмж тусгасан байна. Энэ нь тухайн цаг үеийн нийгмийн байдал, төрийн бодлоготой шууд холбоотой бөгөөд уг хуулийн тусгай

<sup>32</sup> Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). 361 дэх тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

<sup>33</sup> Мөн тэнд.

ангийн “Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд” хэмээх 1 дүгээр бүлгийн 55 дугаар зүйлд: “Хөдөлмөрчин ард түмний засаг төр ба БНМАУ-ын Үндсэн хуулийн ёсоор сонгон байгуулагдсан Ардын хувьсгалт Засгийн газрыг түлхэн унагаах, гутаах султгах буюу эсвэл БНМАУ-ын гадаадаас аюулгүй байх хэрэг ба батлан хамгаалах, мөн түүнчлэн хувьсгалаар байлдан олж авсан аж ахуй, улс төр хийгээд үндэсний хувьсгалын гол дийлэнх ялалтуудыг таслан эвдэх буюу султгах явдалд хандуулагдсан аливаа нэгэн явдлууд нь хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд мөн болно. Тус БНМАУ бол хөдөлмөрчин ард түмний эрх ашгийг хамгаалсан улс болох тул аливаа хөдөлмөрчдийн улсыг эсэргүүцсэн явдлууд мөн нэгэн адил хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд болно” гэж заасан ба ийм хэрэгт ихэвчлэн буудан алах ял оноохоор тогтоосон юм.<sup>34</sup>

“БНМАУ-ын Эрүүгийн хууль” 1961 он

Эрүүгийн хуулийг 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын II чуулганаар 11 бүлэг, 221 зүйлтэй баталж, мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Тус хуулийн 36 дугаар зүйлд “Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа”-г тусгажээ.<sup>35</sup>

“Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хөөн хэлэлцэх хугацаанд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй.

1. Хуульд зааснаар хорих ял оногдуулж болохгүй хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;
2. Хуульд зааснаар хоёр жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гурван жил өнгөрсөн;
3. Хуульд хоёроос доош, таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

<sup>34</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа. 80 дахь тал.

<sup>35</sup> Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 430 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

4. Хуульд таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гэмт хэрэг үйлдсэнээс хойш найман жил өнгөрсөн.

Хэрэв уг этгээд хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдал тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг шинээр үйлдсэн өдрөөс эхлэн тоолно.

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт ба шүүхээс оргон зайлсхийж байгаа бол хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдлыг зогсооно. Энэ тохиолдолд уг этгээдийг албадан саатуулсан буюу түүний хэргээ хүлээсэн, илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. Тэгэхдээ гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй.

Цаазаар авах ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй, түүнийг хорих ялаар солино”.

Мөн хуулийн “Ял шийтгэлийг хөөн эдлүүлж болохгүй хугацаа” хэмээх 37 дугаар зүйлд “Ял шийтгэсэн тогтоолд хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелэгдээгүй дор дурдсан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол биелүүлэх явдалгүй.”<sup>36</sup>

1. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу өөр хөнгөн ялаар шийтгэгдсэн боловч хоёр жил өнгөрсөн;
2. Хоёр жилээс доошгүй хугацаагаар хоригдох, уг нутгаас зайлуулах эсхүл ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялаар шийтгэгдсэн боловч гурван жил өнгөрсөн;
3. Хоёроос дээш, таван жилээс дээшгүй хугацаагаар хоригдох ял шийтгэгдсэн боловч таван жил өнгөрсөн;

---

<sup>36</sup> Мөн тэнд, 431 дэх тал.

4. Таван жилээс дээш хугацаагаар хоригдох ял шийтгэгдсэн боловч найман жил өнгөрсөн.

Хэрэв ял шийтгэгдсэн этгээд ял эдлэхээс зайлсхийсэн буюу нэг жилээс доошгүй хугацаагаар хорих буюу нутаг зааж суулгах эсхүл уг нутгаас зайлуулах ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдал тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг шинээр үйлдсэн буюу ял эдлэхээс зайлсхийсэн этгээд ялаа эдлэхээр ирсэн эсхүл шийтгэгдэж оргосон этгээдийг албадан саатуулсан өдрөөс эхлэн тоолно. Тэгэхдээ шийтгэх тогтоол гарснаас хойш 10 жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол уг тогтоолыг биелүүлж болохгүй.

Цаазаар авах ял шийтгэгдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино” гэж заажээ.

Энэ хуулиар “хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн нэр томъёог анх удаа томъёолон, уг ойлголтыг боловсронгуй болгосон юм. Тухайлбал, уг хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийг нь мөрдөн шалгах явцад оргон зайлсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, уг этгээдийг албадан саатуулсан буюу түүнийг хэргээ илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолохоор, үүнээс гадна нэг төрлийн буюу өөр хөнгөн бус гэмт хэрэг үйлдэхэд хөөн хэлэлцэх хугацаа тасардаг байсныг өөрчилж зөвхөн хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасардаг байхаар хуульчилжээ.

Мөн 1942 оны Эрүүгийн хуулиар тодорхой төрлийн буюу хувьсгалын эсэргүү гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэггүй байсан бол 1961 оны хуулиар тодорхой төрлийн хэрэгт биш зөвхөн цаазаар авах ял оногдуулж болохоос бусад бүх хэрэгт хэрэглэхээр зааснаас гадна 1942 оны хуулиар цаазаар авах ял оногдуулж болох хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг ямар ч тохиолдолд хэрэглэдэг байсныг болиулж үүнийг шүүхийн эрх мэдэлд шилжүүлэн шийдвэрлэх боломжгүй гэж



үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар сольж байхаар<sup>37</sup> болжээ. Үүнээс гадна нэг төрлийн буюу өөр, хөнгөн бус гэмт хэрэг үйлдэхэд хөөн хэлэлцэх хугацаа тасардаг байсныг өөрчилжээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээд урьд үйлдсэн хэргээсээ өөр төрлийн хөнгөн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тоологдсоор байдаг нь тухайн этгээдийн нийгэмд аюултай байдлыг улам даамжруулж байна гэж үзэж, зөвхөн хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасардаг байхаар хуульчилжээ.

Энэ хуулиар эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг 2-8 жил байхаар заасан бол таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг нарийн ялгавартайгаар авч үзэн уг тогтоол нь 10 жилийн дотор гүйцэтгэгдээгүй бол гүйцэтгэх явдалгүй гэсэн ерөнхий баримжаалсан хугацааг өөрчилж, энэ хугацааг гэм буруутай этгээдэд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хугацаагаар ялган 2-8 жил байхаар тогтоож өгсөн юм.

“БНМАУ-ын Эрүүгийн хууль” 1986 он

1961 оны Эрүүгийн хуулийг 1986 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн АИХ-ын Тэргүүлэгчдийн 21 дүгээр зарлигаар шинэчлэн найруулж, 1987 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлжээ. Тус хууль нь 13 бүлэг, 301 зүйлтэй батлагдсан.

Уг хуулийн 4 дүгээр бүлгийн “Ял оногдуулах ба ялаас чөлөөлөх тухай” хэмээх 44 дүгээр зүйлд хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар хуульчилжээ.<sup>38</sup>

“1. Хэрэв дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй:

а) Энэ хуульд зааснаар хорих ял оногдуулж болохгүй гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хоёр жил өнгөрсөн;

<sup>37</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 83 дахь тал.

<sup>38</sup> Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 527 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

- б) Энэ хуульд зааснаар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохгүй гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш гурван жил өнгөрсөн;
  - в) Энэ хуульд зааснаар таван жилээс дээш хугацаагаар хорих эсхүл түүнээс хүнд ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш арван жил өнгөрсөн.
2. Хэрэв дээр дурдсан хугацаа өнгөрөөгүй байхад энэ хуульд зааснаар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шинээр тоолно.
  3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт буюу шүүхээс оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдлыг зогсооно. Энэ тохиолдолд уг этгээдийг албадан саатуулсан буюу түүний хэргээ илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. Тэгэхдээ гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй.
  4. Хуульд зааснаар цаазаар авах ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх түүнд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял хэрэглэнэ”.

Мөн хуулийн 45 дугаар зүйлд “Таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа”-г дараах байдлаар хуульчилжээ.<sup>39</sup>

- “1. Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дор дурдсан хугацаанд биелүүлээгүй бол биелүүлж болохгүй.

<sup>39</sup> Мөн тэнд, 526 дахь тал.

- а) Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн боловч хоёр жил өнгөрсөн;
  - б) Хоёр жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн;
  - в) Таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч таван жил өнгөрсөн;
  - г) Таван жилээс дээш хугацаагаар хорих эсхүл түүнээс хүнд ял шийтгүүлсэн боловч арван жил өнгөрсөн.
2. Хэрэв ялтан ял эдлэхээс зайлсхийсэн буюу хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад гэмт хэрэг шинээр үйлдэж шүүхээр нэг жилээс доошгүй хугацаагаар хорих эсхүл гурван жилээс доошгүй хугацаагаар нутаг заах буюу уг нутгаас зайлуулах ял шийтгүүлсэн бол хөөн хэлэлцэх хугацаа тасарна. Гэмт хэрэг шинээр үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг уг гэмт хэргийг үйлдсэн өдрөөс, ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд ялтан ялаа эдлэхээр эргэж ирсэн буюу түүнийг албадан саатуулсан өдрөөс эхлэн шинээр тоолно. Тэгэхдээ таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол гарсан өдрөөс хойш арван таван жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй.
3. Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ялыг хорих ялаар солино” гэж заажээ.

1986 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар бэхжүүлсэн заалтууд нь 1961 оны Эрүүгийн хуулиас онцын ялгагдах зүйлгүй бөгөөд таван жилээс дээш хугацаагаар хоригдох ял шийтгэгдсэн боловч найман жил өнгөрсөн гэж байсныг таван жилээс дээш хугацаагаар хорих эсхүл түүнээс хүнд ял шийтгүүлсэн боловч 10 жил өнгөрсөн гэж хөөн хэлэлцэх хугацааны дээд хязгаар 10 жил байсныг 15 жил болгон өөрчилжээ.<sup>40</sup>

<sup>40</sup> Г.Гантөмөр, О.Амарсайхан (2004), Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, 84 дэх тал.

## “Эрүүгийн хууль” 2002 он

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 1997 оны 04 тоот зөвлөмж, УИХ-ын 1997 оны 89 дүгээр захирамжийг үндэслэн Засгийн Газраас Эрүүгийн хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн барьсан бөгөөд улмаар 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр УИХ Эрүүгийн хуулийг баталсан.<sup>41</sup> Тус хууль нь ерөнхий, тусгай ангиас бүрдэх бөгөөд 12 хэсэг, 31 бүлэг, 305 зүйлтэй батлагджээ. 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар хуульчилжээ.

“72 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх<sup>42</sup>

72.1 Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй:

72.1.1 хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн;

72.1.2 хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

72.1.3 хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн;

72.1.4 онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин таван жил өнгөрсөн.

72.2. Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ хуулийн 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно.

72.3. Шүүхийн өмнөх шат буюу шүүхийн шатнаас гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан буюу хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.

72.4. Энэ хуульд зааснаар цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх

<sup>41</sup> Эрүүгийн хууль (2002), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, №5.

<sup>42</sup> Б.Баярсайхан нар (2011), Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 715 дахь тал, Хууль зүйн үндэсний хүрээлэн.

шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулна.

72.5. Энэ хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй.

76 дугаар зүйл. Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх<sup>43</sup>

76.1. Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрсөн бол ялтны үндсэн болон нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй.

76.1.1 хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч гурван жил өнгөрсөн;

76.1.2 таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч таван жил өнгөрсөн;

76.1.3 таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван жил өнгөрсөн;

76.1.4 арван жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн боловч арван таван жил өнгөрсөн.

76.2 Ялтан ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Энэ тохиолдолд ялтан цагдан хоригдсон буюу өөрөө сайн дураараа хэргээ илчлэн ирсэн өдрөөс сэргээн тоолно.

76.3 Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг арван таван жил өнгөртөл биелүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулна.

---

<sup>43</sup> Мөн тэнд, 718 дахь тал.

76.4 Ялтан энэ хуулийн 76.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно.

76.5 Энэ хуулийн тусгай ангид заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн ялтанд энэ зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй” гэж зохицуулсан байна.

2002 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг өмнө нь дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулиудтай харьцуулахад цоо шинэ байдлаар хуульчилсан гэж үзэж болох юм. Учир нь тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан өөрөөр хэлбэл, гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд хэмээн ангилж, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлагад татах хугацааг гэмт хэргийн ангиллаас хамааруулж тоолохоор зохицуулсан. Уг хугацааг зургаан сараас 25 жил, таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацааг 3-15 жил байхаар хуульчилжээ.

#### “Эрүүгийн хууль” 2015 он

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох”<sup>44</sup> зорилтыг дэвшүүлсний үндсэн дээр 2002 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах ажлыг эхлүүлж 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр УИХ-аас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон. Гэвч 2016 оны УИХ-ын ээлжит сонгуулиар шинээр бүрдсэн УИХ Эрүүгийн

<sup>44</sup> Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр.

<https://www.legalinfo.mn/annex/details/5591?lawid=8722>

хуулийн шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийг 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хэлэлцэж, хуулийг дагаж мөрдөх хугацааг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулсан юм.

Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар хуульчилсан.<sup>45</sup> Үүнд:

“1.10 дугаар зүйл. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа

1. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй:
  - 1.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;
  - 1.2. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;
  - 1.3. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;
  - 1.4. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн.
  - 1.5. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс

---

<sup>45</sup> 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон байдлаар.

бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.

2. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно.
3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно.
4. Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй.
5. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна.
6. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.”

Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн хувьд хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн ангиллаас хамаарч биш оногдуулж буй ялын дээд, доод хэмжээтэй уялдан тоологдохоор зохицуулагдсан. Ингэхдээ зөвхөн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар хуульчилсан гэмт хэргүүдэд л хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтойгоор хуульчлагдсан юм. Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэгт буюу торгох ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор зохицуулалтыг нэмж хуульчилсан байна. Мөн тус нэмэлт, өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...гэмт хэрэг үйлдсэн



өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж заасныг тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй уялдуулан “...гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно...” гэж өөрчлөн найруулсан байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь хэд хэдэн сул тал агуулж байсан. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн хүн (тэдгээрийн өмгөөлөгч) эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, өмгөөлөгчид хүндэтгэн үзэх шалтгаан дурдаж шүүх хуралдааныг хойшлуулах, үндэслэлгүй хүсэлт, гомдол олонтаа гаргах, үндэслэлгүйгээр шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, хэргийг буцаах гэх мэтээр сунжруулж, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг дуусгах сонирхолтой байдаг. Үүнээс шалтгаалж шүүхээр шийдвэрлэгдэж буй ихэнх хэргийн хувьд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч, шүүхийн ачаалал нэмэгдэхэд хүрдэг. Энэхүү зохицуулалтын талаар УИХ-ын гишүүн О.Баасанхүү шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөхөөс өмнө буюу 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хаврын ээлжит чуулганы үеэр “...энэ заалтын хоёрыг хэрвээ би унших юм бол гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс гэдэг нь яах вэ тэр хүнийг жишээлбэл, доромжилсон өдрөөс дараа нь анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох гэхээрээ нөгөө хүн бодож байснаа гэнэтхэн одоо шүүхэд хандаад шүүхийн шийдвэр гаргах хүртэл бол хөөн хэлэлцэх хугацаа хүчинтэй байна гэж ойлголоо шүү дээ. Тэгэхээр хүн хэзээ ч шүүхэд хандаж болох нь ээ...”<sup>46</sup> гэж ярьж байжээ. Дээрх дэвшүүлж буй асуудал нь нэг талаас анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолбол үүсэх асуудал төдийгүй нөгөө талаас гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтын эрх зүйн хийдлийг хууль батлагдахаас өмнө анхааруулан хэлж байсан гэдгийг дурдах нь зүйтэй.

<sup>46</sup> Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс.

Улмаар дээрх зохицуулалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөлт оруулсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зориудаар удаашруулдаг явдлыг багасгах үндэс болсон гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “...гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно...” гэж өөрчлөн найруулсан нь ямар ач холбогдолтой байх талаар УДШ-ийн шүүгч Б.Батцэрэн Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны үеэр “...Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолох зарчмыг сэргээн хуульчилснаар өргөдөл, гомдол гаргаж хэргийн ажиллагааг удаашруулдаг ийм явдал байхгүй болно”<sup>47</sup> гэж тайлбарлаж байжээ. Энэхүү тайлбар нь магадгүй, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн хийдэл, тэр дундаа гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох эсхүл яллагдагчаар татах хүртэл тоолох асуудалд практикт ажиллаж буй шүүгчийн хувьд шийдвэрлэж болох гаргалгааг тодорхойлон хэлсэн гэж үзэж болох юм.

2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийг харьцуулан үзэхэд хөөн хэлэлцэх хугацааны хувьд доод хязгаар нь зургаан сар байсан нь нэг жил болж, дээд хязгаар нь 25 жил байсныг 20 жил, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг болон бүх насаар хорих ялтай хэргүүд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар хуульчлагджээ. Түүнчлэн 2002 оны Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэн этгээд 72.1-д заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай үйлдвэл хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд уг хугацааг сүүлчийн хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тоолно” гэж зохицуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрөөгүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн гэмт хэргийг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр тоолно” гэж

<sup>47</sup> Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлээс.

хуульчилсан. Өөрөөр хэлбэл, 2015 оны Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацаа тасрах гэсэн ойлголт байхгүй болсон юм.

2015 оны хуулиар хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байхаар заасан нь 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай адил байгаа бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар бүх насаар нь хорих ялыг шинээр хуульчилж уг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэж зохицуулсан нь өмнөх хуулиасаа ялгаатай байна. Мөн 2015 оны Эрүүгийн хуулиар тодорхой төрлийн буюу татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байхаар шууд тусгаж өгсөн нь онцлог болжээ.

## НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Дээрхээс дүгнэвэл, эрүүгийн эрх зүйд хуулийн үйлчлэх хугацаа, гэмт хэрэг үйлдсэн цаг, хөөн хэлэлцэх болон ялын хугацаа зэрэг олон хугацааны ойлголт байдаг бөгөөд үүнээс гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа гэсэн хоёр төрөлд хуваан үздэг төдийгүй энэ хугацаа нь гэмт хэрэг, эрүүгийн хариуцлага, ялтай холбогддог.

Тэгвэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг шинэ үеийн болон нэн шинэ үеийн төрөлжсөн Эрүүгийн хуулиуд болох 1926, 1929, 1934 оны Шүүхийн цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002, 2015 оны Эрүүгийн хуулиар хуульчлан зохицуулж иржээ. 1926 болон 1929 оны Шүүх цаазын бичигт хөөн хэлэлцэх хугацааны нэг төрлийг л хуульчилсан бол 1934 оны Шүүхийн цаазын бичигт таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацааны талаар анх удаа оруулж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулж болох ялын байдалтай нь харьцуулан 3-10 жил байхаар нарийвчлан тогтоож өгсөн байна. 1942 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар зохицуулсан заалт нь 1934 оны Шүүх цаазын бичгийн заалттай харьцуулахад зарчмын ялгаа байхгүй байх бөгөөд хувьсгалын эсэргүү гэмт хэрэг

үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхийг хориглох заалтыг шинээр нэмж оруулжээ. Харин 1961 оноос хөөн хэлэлцэх хугацаа зогсох, тасрах гэсэн ойлголтыг шинээр хуульчилж, зөвхөн цаазаар авах ял оногдуулж болохоос бусад бүх хэрэгт уг хугацааг тооцохоор хуульчилсан бол 1986 оны Эрүүгийн хууль нь 1961 оны Эрүүгийн хуулиас онцын ялгагдах зүйлгүй бөгөөд хугацааны интервалын хувьд бага зэрэг өссөн, буурсан байдлаар хуульчлагджээ. Харин 2002 оноос хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамаарч тооцдог байсан бол 2015 оноос оногдуулж буй ялын төрөл, түүний дээд, доод хэмжээтэй уялдуулан тооцохоор хуульчилсан байна.

# ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжид хөөн хэлэлцэх хугацааны талаар хэрхэн тусгасан байдлыг авч үзэх нь нэг талаас гадаад орнуудын Эрүүгийн хуульд энэ талаар тогтоосон хэм хэмжээний нийтлэг болон ялгаатай талыг танин мэдэх, нөгөө талаасаа өөрийн орны Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар тогтоосон хэм хэмжээг бусад орныхтой харьцуулан үзэх, туршлага судлах зэрэг олон талын ач холбогдолтой.

Эрүүгийн хууль нь тухайн улс орныхоо соёл иргэншил, түүхэн уламжлал, нийгэм, эдийн засаг, улс төрийн байгууламж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөр өөр байдаг. Англи-Америкийн эрүүгийн хууль тогтоомжид Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацааг заадаггүй, тэрчлэн хөөн хэлэлцэх хугацаа гэсэн институт байдаггүй.<sup>48</sup> Иймд энэхүү судалгааны хүрээнд Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийн орнуудыг харьцуулан судлаагүй бөгөөд Ром-Германы буюу эх газрын болон холимог эрх зүйн системийн улс орнуудаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ), Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Оросын Холбооны Улс (ОХУ)-д гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсан байдгийг судлан өөрийн орны зохицуулалттай харьцуулан үзэхийг зорилоо.

## 2.1. ЭХ ГАЗРЫН (РОМ-ГЕРМАНЫ) ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ

Эх газрын эрх зүйн тогтолцоо нь XII-XIII зууны үед Европ тивд Ромын эрх зүйн агуулгаар үүссэн. Энэ тогтолцооны онцлог шинж

---

<sup>48</sup> Д.Баярсайхан (2011), Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 42 дахь тал.

нь бичмэл эрх зүйд тулгуурласан байдаг тул хуулийг эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж гэж үздэг. Эрүүгийн хуулиудыг төрөлжүүлэн нэгтгэсэн байдаг. Шүүхийн прецедентийг хүлээн зөвшөөрдөггүй. Эрүүгийн эрх зүйн хориглолтыг томъёолох өвөрмөц арга, түүнийг хуульд хийсвэрлэн тусгах замаар заасан, хэллэг нь туйлын тодорхой бөгөөд тэдгээрийг хамгийн түгээмэл тохиолдолд хэрэглэдэг нь энэхүү тогтолцооны онцлог юм.<sup>49</sup> Түүнчлэн, Эрүүгийн хууль тогтоомж нь бүрэн кодификацчилагдаагүй, хагас буюу хэсэгчилсэн байдлаар системчлэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хууль тогтоомж нь зөвхөн нэг хуулиас биш хэд хэдэн зэрэгцсэн Эрүүгийн хууль, хуульчилсан актаас бүрдэх ба ихэнхдээ ерөнхий анги нь хагас буюу хэсэгчилж хуваарилагдсан байх ба тусгай ангийн институт нь кодификацчилагдсан байдгаараа онцлогтой.<sup>50</sup> Эх газрын эрүүгийн эрх зүйн системийн тогтолцоотой улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн хуульчилсныг дор авч үзье.

### 2.1.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь 1949 оны ХБНГУ-ын Үндсэн хууль, 1998 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр редакц хийсэн Эрүүгийн хууль (энэ хуульд хамгийн сүүлд 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)<sup>51</sup>, Холбооны тусгай хууль, мужийн эрүүгийн хууль тогтоомжоос бүрддэг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5-р хэсгийн 1-р бүлэгт “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн бүлгийг хуульчилсан байдаг ба уг бүлгийн 78 дугаар зүйлд:<sup>52</sup>

- а) Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш 30 жил өнгөрсөн;
- б) Арав буюу түүнээс дээш жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;

<sup>49</sup> С.Нарангэрэл (1999), Монгол Улсын эрүүгийн эрх зүй, 372 дахь тал.

<sup>50</sup> Мөн тэнд.

<sup>51</sup> German Criminal Code.  
[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)

<sup>52</sup> Мөн тэнд, 78 дугаар зүйл.  
[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)

- в) Таваас доошгүй, арван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;
- г) Нэгээс доошгүй, таван жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;
- д) Нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу бусад төрлийн ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байхаар тогтоожээ.

Дээрхээс үзвэл ХБНГУ-ын Эрүүгийн хуулиар тогтоосон эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа нь манай одоогийн дагаж мөрдөж байгаа хуулиас хүнд байгаа боловч гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын төрөл, хэмжээнээс хамаарч тоолохоор зохицуулж байгаа байдал нь манай улсын зохицуулалттай ижил. Харин “Хор уршиг гэмт үйлдлээс хойш учирсан бол хор уршиг учирсан өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолно”<sup>53</sup> гэж хуульчилсан нь манай эрүүгийн эрх зүйн зохицуулалтаас ялгаатай байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн нэг онцлог нь бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулсан нь манай Эрүүгийн хуулийн зохицуулалтаас ялгаатай. Монгол Улс 2015 оны Эрүүгийн хуульд ялын шинэ төрөл болох бүх насаар хорих ялыг шинээр хуульчилж, уг ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар тусгасан юм.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх хугацааг уг хуулийн ерөнхий ангийн тавдугаар хэсгийн хоёрдугаар бүлгийн 79 дүгээр зүйлд хуульчилсан байна.<sup>54</sup>

“Шүүхийн ял болон албадлагын бусад арга хэмжээ оногдуулсан тогтоолыг дор дурдсан хугацаанд биелүүлээгүй бол түүнийг биелүүлэх хугацаа хүчингүй:

<sup>53</sup> Мөн тэнд, 78а дугаар зүйл.

<sup>54</sup> Мөн тэнд, 79 дүгээр зүйл.

- а) Бүх насаар нь хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй;
- б) Арваас дээш жил хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 25 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- в) Таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 20 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- г) Нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг 10 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- д) Нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан эсхүл 30 өдрийн орлогоос дээш хэмжээгээр торгох ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг 5 жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- е) 30 өдөр хүртэлх орлогын хэмжээгээр торгох ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг 3 жилийн хугацаанд биелүүлээгүй бол” гэж заасан байна.

Мөн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолын хөөн хэлэлцэх хугацааг хүчин төгөлдөр болсон өдрөөс уг ялыг биелэгдэх хүртэл тоолно гэж заасан нь ихээхэн ач холбогдолтой юм. Учир нь тухайн шийтгэх тогтоолыг хуульд заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд биелүүлэхгүй байх боломжийг хуулиар олгож байна. Энэ нь тухайн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хэр хэмжээ, гэмт хэргийн хохирол, хор уршгаас шалтгаалан зарим төрлийн буюу хөнгөн гэмт хэрэгт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зардал, цаг хугацаа, хүн хүч, ажлын ачаалал гэх мэт олон төрлийн зайлшгүй гарах зардлыг бууруулах ач холбогдолтой. Харин манай улсын хувьд шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд ялаас чөлөөлөх хугацааг хуульчилж өгөөгүй.



### 2.1.2. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хууль нь 1953 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд ерөнхий болон тусгай ангиас бүрдсэн 42 бүлэг, 372 зүйлтэй. Ерөнхий ангийн нэгдүгээр дэвтрийн долоодугаар хэсгийн 77 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг үйлдсэн гэмт хэрэгт нь оногдуулж болох ялын төрөл хэмжээтэй нь харьцуулан дараах байдлаар хуульчилжээ.<sup>55</sup> Үүнд:

- “а) Цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш гучин жил өнгөрсөн;
- б) Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн;
- в) Арван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн;
- г) Таван жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;
- д) Таван жил хүртэл хугацаагаар хорих буюу эд хөрөнгө хураах, торгох (500 воноос дээш) ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;
- е) Бага хэмжээгээр торгох (500 хүртэл вон) буюу баривчлах ял (1-30 хоног) оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахгүй байх”-аар заасан байна.

БНСУ-д гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын төрөл, хэмжээнээс хамаарч тоолохоор хуульчилсан. Мөн цаазаар авах ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолдог бөгөөд цаазаар авах, хорих, эд хөрөнгө хураах, торгох, баривчлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхээр зохицуулснаараа манай улсын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны

<sup>55</sup> Criminal code.

<https://www.refworld.org/pd/fid/3f49e3ed4.pdf?fbclid=IwAR18CNwc-G9McbrKQDE4FNcDdauNEd5mILyWy8Wsg3XtNL75nNoAvpXskYs>

зохицуулалтаас илүү боловсронгуй буюу ялын бүх төрөлд хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой байдлаар хуульчилжээ. Харин манай улсын хувьд зорчих эрхийг хязгаарлах, торгох болон хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт л хөөн хэлэлцэх хугацааг тоолж байна.

## 2.2 ХОЛИМОГ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ

Дэлхийн эрх зүйн системийн зонхилох гол загвар болох Англи-Америкийн болон Эх газрын системүүд нь хоорондоо зааг ялгаатай, онцлог хэв шинжийг тусгаж ирсэн боловч улс, үндэстнүүдийн соёл, түүхэн уламжлал, тэдгээрийн өвөрмөц байдлаас хамаарч янз бүрийн тогтолцоо, бүлүүдийг бий болгон хөгжүүлснийг харж болно. Ялангуяа хөгжингүй болон хөгжиж буй улс орнууд, тэрчлэн шинэ тутам үүсэн байгуулагдсан болон хот улс, жижиг арлын орнуудад үндсэн ба зарим системийн хэв шинж, соёл, тогтолцооны хосолсон буюу холимог хэлбэр илэрч байна. Холимог эрүүгийн эрх зүй гэдэг нь түүхэн сонголтын болон түүхэн цаг үеийн нөхцөлд өөрийн орны сонгосон аль нэг системийг хөгжүүлэх явцад эх газрын болон Англи-Америкийн системээс зээлдэн авсан буюу өмнөх системээ халж, өөр системд шилжихдээ системүүдийн хэв шинж холилдсон буюу аль нэг систем нь давамгайлсан хандлага бий болсон байдлыг хэлнэ.<sup>56</sup>

### 2.2.1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь эрүүгийн эрх зүйн маш өвөрмөц онцлогийг тусгасан байдаг бөгөөд хэд хэдэн системийн шинжийг өөртөө хослуулан хадгалахын сацуу өөрийн гэсэн бие даасан онол-практикийг хослуулан хөгжүүлж байна. БНХАУ нь 1979 онд шинэ Эрүүгийн хуулиа баталсан бөгөөд 1997 онд зарим нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталжээ.<sup>57</sup> Хөөн хэлэлцэх хугацааг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн Наймдугаар хэсэгт Хүчинтэй хугацаа хэмээн хуульчилж өгчээ.<sup>58</sup>

<sup>56</sup> Д.Баярсайхан (2011), Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 55 дахь тал.

<sup>57</sup> Criminal Law of the People's Republic of China.  
<https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm>

<sup>58</sup> Д.Баярсайхан (2011), Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 58 дахь тал.

“87 дугаар зүйл. Ял хийгээд доорх хугацаанаас хэтэрсэн байвал нэхэмжлэн заалдахгүй.

(Нэг) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жил үл хүрэх хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт таван жил өнгөрөн байвал;

(Хоёр) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь таван жилээс дээш, арван таван жил үл хүрэх хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт арван жил өнгөрсөн байвал;

(Гурав) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь арван жилээс дээш хугацаатай хорихоор шийтгэгдэх ёстой байтал нэгэнт арван таван жил өнгөрсөн байвал;

(Дөрөв) Хуулиар тогтоосон хамгийн хүнд эрүү шийтгэл нь хугацаагүй хорих, алахаар шийтгэх ёстой байтал нэгэнт хорин жил өнгөрсөн байвал, хэрэв хорин жилийн хойно заавал нэхэмжлэн заалдах хэрэгтэй гэж үзвэл эрх биш Ардын дээд байцаах хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх хэрэгтэй.

88 дугаар зүйл. Ардын байцаах хороо, Дотоодын хамгаалах байгууллага, Улсын амар төвшнийг хамгаалах байгууллага хэрэг болгон туршин байцаах буюу Ардын шүүх хороо хэргийг хүлээн авсны дараа туршин байцаалт буюу шүүн таслалтаас зайлсан байвал нэхэмжлэн заалдах хугацааг хязгаарлахгүй.

Хорлогдогсод нэхэмжлэн заалдах хугацааны дотор илчлэн заалдсан байхад Ардын шүүх хороо, Ардын байцаах хороо, Дотоодын хамгаалах байгууллага хэрэг болгох ёстой байтал үл болгосон байвал нэхэмжлэн заалдах хугацаанд хязгаарлагдахгүй.

89 дүгээр зүйл. Нэхэмжлэн заалдах хугацааг ял хийсэн өдрөөс эхлэн бодно. Ялт үйл ажиллагаа нь залгалдсан буюу үргэлжилсэн байдалтай байвал ялт үйл ажиллагааны илэрсэн өдрөөс эхлэн бодно. Нэхэмжлэн заалдах хугацаанд дахиж ял хийсэн байвал өмнөх ялын нэхэмжлэн заалдах хугацааг хойших ялыг хийсэн өдрөөс эхлэн бодно.<sup>59</sup>”

---

<sup>59</sup> Э.Зууннасан, Б.Батзориг (2006), БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль.

БНХАУ-ын хувьд 60 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулдаг буюу цаазаар авах ялыг маш өргөн хүрээнд хэрэглэдгээрээ онцлогтой.<sup>60</sup> Гэсэн хэдий ч бүх насаар хорих ял оногдуулах гэмт хэрэг болон алахаар заасан гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааг хорин жил байхаар тогтоож өгсөн нь өвөрмөц зохицуулалт болжээ. Мөн хөөн хэлэлцэх хугацаа зогсох, тасрах, түүнийг хэрхэн тоолох талаар зохицуулалтыг хуульчилсан байна.

### 2.2.2. Оросын Холбооны Улс

ОХУ-д Төрийн Думаас 1995 оны 7 дугаар сарын 19-ний өдөр баталж 1996 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдсөн дөрөв дэх<sup>61</sup> Эрүүгийн хууль (тус хуульд хамгийн сүүлд 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)<sup>62</sup> үйлчилж байгаа бөгөөд уг хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр хэсгийн "Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх" хэмээх 11 дүгээр бүлгийн 78 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг доорх байдлаар тогтоожээ.

“Гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.”<sup>63</sup>

- а) Нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;
- б) Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил өнгөрсөн;
- в) Хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;
- г) Онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн” гэж заасан ба хугацааг тоолох журам, нөхцөлийг тогтоосон байна.

Мөн хугацааг тогтоосон үндэслэл (гэмт хэргийн ангиллаар) ба хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа

<sup>60</sup> Д.Баярсайхан (2011), Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 58 дахь тал.

<sup>61</sup> ОХУ-д 1922, 1923, 1960, 1995 онд тус тус Эрүүгийн хууль батлагдаж байжээ.

<sup>62</sup> Уголовный кодекс Российской Федерации.  
[http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_10699/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/)

<sup>63</sup> Мөн тэнд, ОХУ-ын Эрүүгийн хууль, 78 дугаар зүйл.

хэрэглэхгүй гэж заасан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил юм.

Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны талаар ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дөрөвдүгээр хэсгийн 12 дугаар бүлгийн 83 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилжээ.<sup>64</sup>

“Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш доорх хугацаанд түүнийг биелүүлээгүй (биечлэн эдэлж дуусаагүй) бол биелүүлж болохгүй. Энэ тохиолдолд ялтанг уг ялыг эдлэхээс чөлөөлнө.

- а) Нийгмийн хор аюулаар бага гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг хоёр жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- б) Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг зургаан жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- в) Хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг арван жилийн хугацаанд биелүүлээгүй бол;
- г) Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг арван таван жилийн хугацаанд биелүүлээгүй бол биелүүлж болохгүй” гэж эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаатайгаа ижил байдлаар тогтоожээ.

Таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааны тухай ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэм хэмжээ нь тухайлбал, хугацааг тоолох журам, нөхцөл нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ерөнхийдөө адил боловч ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасардаггүй, харин зогсдог байхаар хуульчилснаараа онцлогтой. Мөн хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байхаар тогтоожээ. ОХУ-ын хувьд Эрүүгийн хууль нь бүрэн системчлэгдсэн (кодификацчилагдсан) байдаг бөгөөд нэгдмэл төрөлжсөн нэг Эрүүгийн хуультай гэдгээрээ манай улстай ижил. Үүнээс гадна гэмт хэргийг хөөн

<sup>64</sup> Мөн тэнд, ОХУ-ын Эрүүгийн хууль, 83 дугаар зүйл.

хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамааруулан зохицуулсан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай адил байна.

#### ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Дээрх улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааны хоёр төрлийг хоёр хэлбэрээр өөрөөр хэлбэл, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон оногдуулж болох ялын дээд хэмжээтэй нь харьцуулан, харин таслан шийдвэрлэх шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацааг гэмт хэргийн ангиллаар болон таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан ялын төрөл, хэмжээтэй нь харьцуулан тогтоосон байна.

Хөөн хэлэлцэх хугацааг тоолох нөхцөл, журам нь ерөнхийдөө нийтлэг боловч хугацааны хязгаар нь харилцан адилгүй байна. Энэ нь тухайн улс орны эрүүгийн эрх зүйн бодлого, гэмт хэргийн гаралт, зан заншил, үндэсний онцлогтой холбоотойгоор тайлбарлагдах бөгөөд дэлхийн хөгжлийн чиг хандлага, гарч буй гэмт хэргийн нөхцөл байдалтай (терроризм, хүн төрөлхтний болон энх тайвны эсрэг гэмт хэрэг, үндэстэн дамнасан хэрэг) уялдан хөөн хэлэлцэх хугацааны хязгаарыг багасгах биш нэмэгдүүлэх хандлага давамгайлж байгаа нь харагдлаа. Манай улсын хувьд хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн зорчих эрхийг хязгаарлах, торгох болон хорих ялтай гэмт хэрэгт тоолохоор зохицуулсан бөгөөд харин таслан шийтгэх тогтоол биелүүлэх хугацаан дээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байхаар тусгасан буюу хуулиар зохицуулж өгөөгүй. Харьцуулсан судалгаанаас үзэхэд улс орнууд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг оногдуулж буй ялын бүх төрөл дээр тооцдог байхаар хуульчилсан нь харагдаж байна.

## ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААТАЙ ХОЛБООТОЙ ТООН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хэргийг хэрэгсэхгүй болгох хуулийн хэд хэдэн үндэслэл байдаг бөгөөд үүний дотор хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгох эрх зүйн зохицуулалттай. Хэрэв тухайн хэрэг прокурорын хяналтад буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байх хугацаанд эсвэл шүүхийн шатанд хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан бол хэргийг хэрэгсэхгүй болгодог. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр жилд хэчнээн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэдгийг судалж үзэхийн тулд прокурорын байгууллага болон шүүхийн шийдвэрийн 2017 оноос хойших тоон мэдээг энэхүү судалгаанд ашигласан болно.

### 3.1. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Прокурорын байгууллагаас 2017-2021 оны тавдугаар сарын байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо, хэрэг бүртгэлтийн хаасан хэрэг, мөрдөн байцаалтын шатанд хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо болон үүнээс хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийн тоог харьцуулан хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 1. Улсын ерөнхий прокурорын 2017-2020 оны  
жилийн эцсийн тайлан, 2021 оны тавдугаар сарын байдлаар  
бүртгэгдсэн тоон мэдээлэл<sup>65</sup>*

| № | Он             | Үзүүлэлт                                                      |                                       |                                                                                             |                                                                                    |
|---|----------------|---------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|
|   |                | Хэрэг<br>бүртгэлт,<br>мөрдөн<br>байцаалт<br>явуулсан<br>хэрэг | Хэрэгсэх-<br>гүй<br>болгосон<br>хэрэг | Хөөн<br>хэлэлцэх<br>хугацаа<br>дууссан гэх<br>үндэслэлээр<br>хэрэгсэхгүй<br>болсон<br>хэрэг | Хаасан,<br>хэрэгсэхгүй<br>болсон нийт<br>хэргийн<br>тоонд<br>харьцуулсан<br>хувиар |
| 1 | 2017           | 82 013                                                        | 9 453                                 | 3 327                                                                                       | 35.1                                                                               |
| 2 | 2018           | 69 559                                                        | 617                                   | 140                                                                                         | 22.6                                                                               |
| 3 | 2019           | 105 686                                                       | 739                                   | 169                                                                                         | 22.8                                                                               |
| 4 | 2020           | 90 620                                                        | 31 541                                | 3 845                                                                                       | 12.1                                                                               |
| 6 | 2021.<br>V сар | 43 295                                                        | 6 464                                 | 1 127                                                                                       | 17.4                                                                               |


Дээрх хүснэгтээс харвал хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон буюу хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн хэрэг нь хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн нийт хэргийн 2017 онд 35.1 хувь, 2018 онд 22.6, 2019 онд 12.1, 2021 оны тавдугаар сарын байдлаар 17.4 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл 2017 онд хамгийн их буюу 35.1 хувийг эзэлж байгаа нь 2002 оны Эрүүгийн хууль болон шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль үйлчилж эхэлсэнтэй холбоотой хэмээн үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, 2017 оны эхний хагас жилд 2002 оны Эрүүгийн хуулийг, харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх болсон. Үүнтэй холбоотойгоор зарим гэмт

<sup>65</sup> Улсын Ерөнхий прокурорын 2012-2021 оны тавдугаар сар дуусталх тайлан мэдээ.



хэргийн хувьд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тус гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг өмнөх хуулиас багаар тогтоосон нь Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэл болж бусад онуудтай харьцуулахад илүү олон хэргийг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн гэж үзэж болох юм.

*График 1. Дээрх статистикаас хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон нийт гэмт хэргийн тоог жилээр нь харьцуулбал:*




Прокурорын байгууллагын 2017 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт хэргийн 12 орчим хувийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд 2018, 2019 онд тус бүр нэг орчим хувийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэснээс үзэхэд 2018 оноос хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн хэргийн тоо огцом буурсан боловч эргээд 2020 оноос огцом нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин 2017 оны тоон мэдээнээс харахад хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо өндөр хувь эзэлж байгаа нь тухайн онд нэг хуулийн үйлчлэл дуусаж, шинэ хууль үйлчилж эхэлсэнтэй холбоотой байж болох юм. Мөн 2020 оноос 2021 оны тавдугаар сар хүртэлх хугацаанд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо хэрэгсэхгүй болгосон нийт хэргийн тоотой харьцуулахад буурсан хэдий ч тооны хувьд өссөн үзүүлэлттэй байна.

### 3.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр 2017-2020 онд шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тоон үзүүлэлтийг харьцуулан үзлээ.

*График 2. 2017-2020 онд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болсон хэргийн тоон үзүүлэлт*



Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль мөрдөгдөж эхэлснээс хойш 2020 оныг дуустал гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн 255<sup>66</sup> шийдвэр байна. Дээрх дөрвөн жилийн нийт тоон үзүүлэлтийг жил тус бүрээр нь харьцуулан харвал хамгийн их буюу хэрэгсэхгүй болгосон нийт шийдвэрийн 54 орчим хувийг 2019 онд гаргасан бол 2018, 2020 онд тус бүр 20 орчим хувь буюу нийт шийдвэрийн 40 хувийг, 2017 онд зургаа орчим хувийг гаргажээ. Бусад гурван жилийн үзүүлэлттэй харьцуулахад 2017 онд хамгийн бага байгаа нь хуулийн хэрэгжиж эхэлсэн хугацаатай холбоотой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тухайн оны хуулийн хэрэгжилтийг хагас жилээр тооцохоор байгаа юм. Дээрх тоон үзүүлэлтийг зүйлчлэл тус бүрээр задлан Хүснэгт 2-т харуулав.

<sup>66</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) цахим сангаас 2021 оны тавдугаар сард хийсэн шүүлтийн үр дүнд үндэслэв.

*Хүснэгт 2. 2017-2020 онд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссантай холбоотойгоор хэрэгсэхгүй болгосон хэргийн тоон үзүүлэлт*

| №  | Эрүүгийн хуулийн зүйл, заалт | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | Нийт |
|----|------------------------------|---------|---------|---------|---------|------|
| 1  | 11.3.1                       | -       | 1       | -       | -       | 1    |
| 2  | 11.4.1                       | 2       | 12      | 20      | 4       | 38   |
| 3  | 11.4.2.1                     | -       | -       | 1       | -       | 1    |
| 4  | 11.4.2.2                     | -       | 1       | -       | -       | 1    |
| 5  | 11.5.1                       | -       | 2       | 2       | -       | 5    |
| 6  | 11.6.1                       | 1       | 2       | 26      | 9       | 37   |
| 7  | 11.6.2                       | 2       | 3       | 16      | 7       | 28   |
| 8  | 11.7.1.1                     | 1       | 3       | 7       | 2       | 12   |
| 9  | 11.7.1.2                     | 1       | 2       | 2       | -       | 5    |
| 10 | 11.7.2.3                     | -       | 1       | -       | 1       | 2    |
| 11 | 12.5.1                       | -       | -       | -       | 1       | 1    |
| 12 | 13.5.1                       | -       | -       | 1       | -       | 1    |
| 13 | 15.1.2                       | -       | -       | 1       | -       | 1    |
| 14 | 16.8.1                       | -       | 1       | -       | -       | 1    |
| 15 | 17.1.1                       | 2       | -       | 1       | -       | 3    |
| 16 | 17.1.2                       | -       | -       | 1       | -       | 1    |
| 17 | 17.2.1                       | -       | -       | 1       | -       | 1    |
| 18 | 17.2.2                       | -       | -       | 1       | 1       | 2    |
| 19 | 17.3.1                       | 1       | -       | 3       | 1       | 5    |
| 20 | 17.3.2.2                     | 2       | -       | 4       | 3       | 9    |
| 21 | 17.4.1                       | -       | 1       | 2       | -       | 3    |

*Хүснэгт 2-ын үргэлжлэл*

|             |         |           |           |            |           |            |
|-------------|---------|-----------|-----------|------------|-----------|------------|
| 22          | 17.5.1  | -         | 2         | 7          | 3         | 12         |
| 23          | 17.7.1  | -         | 1         | 4          | 1         | 6          |
| 24          | 17.8.1  | -         | 4         | 4          | 1         | 9          |
| 25          | 17.11.2 | -         | -         | 1          | -         | 1          |
| 26          | 18.3.1  | -         | -         | -          | 1         | 1          |
| 27          | 18.5.1  | -         | 3         | -          | 1         | 4          |
| 28          | 18.6.1  |           | 1         | 5          | 5         | 11         |
| 29          | 20.16.1 | -         | 1         | -          | -         | 1          |
| 30          | 21.1.1  | -         | -         | 1          | -         | 1          |
| 31          | 21.2.1  | 1         | 6         | 9          | 2         | 18         |
| 32          | 21.5.1  | -         | -         | 2          | 1         | 3          |
| 33          | 21.7.1  | -         | 1         | 1          | -         | 2          |
| 34          | 22.1.1  | -         | 1         | -          | -         | 1          |
| 35          | 22.4.3  | -         | -         | 1          | -         | 1          |
| 36          | 22.4.4  | -         | 1         | -          | -         | 1          |
| 37          | 22.10.1 | 1         | -         | 1          | -         | 2          |
| 38          | 23.1.1  | -         | -         | 1          | 1         | 2          |
| 39          | 23.2.1  | -         | -         | 1          | 1         | 2          |
| 40          | 23.3.1  | -         | -         | -          | 2         | 2          |
| 41          | 23.5.1  | -         | -         | 1          | -         | 1          |
| 42          | 24.6.1  | -         | 1         | 2          | -         | 3          |
| 43          | 27.10.1 | -         | 3         | 5          | 1         | 9          |
| 44          | 27.11.1 | -         | -         | 2          | 1         | 3          |
| 45          | 28.4.1  | -         | 1         | -          | -         | 1          |
| <b>Нийт</b> |         | <b>14</b> | <b>55</b> | <b>137</b> | <b>50</b> | <b>255</b> |

Дээрх хүснэгтэд дурдсан тоон үзүүлэлтээс харахад 45 төрлийн гэмт хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэснээс хамгийн их давтамжтай шийдвэр нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг буюу “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-т хамаарах хэргүүд байна. Үүний дараа Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг буюу “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, 21 дүгээр бүлэг буюу “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг”-т хамаарах гэмт хэргүүд оржээ.

Хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн шийдвэрийн эзлэх хувийг Эрүүгийн хуулийн бүлгээр авч үзвэл 11 дүгээр бүлэгт хамаарах гэмт хэрэг 51 орчим хувь, 12, 13, 15, 16, 20, 28 дугаар бүлэгт хамаарах гэмт хэрэг тус бүр 0.5 хувь, 17 дугаар бүлэгт хамаарах гэмт хэрэг 20 орчим хувь, 18 дугаар бүлэгт хамаарах гэмт хэрэг зургаа орчим хувь, 21 дүгээр бүлэгт хамаарах гэмт хэрэг ес орчим хувь, 22 дугаар бүлэгт хамаарах гэмт хэрэг хоёр хувь, 23 дугаар бүлэгт хамаарах гэмт хэрэг гурван хувь, 24 дүгээр бүлэгт хамаарах гэмт хэрэг нэг хувь, 27 дугаар бүлэгт хамаарах гэмт хэрэг таван хувийг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн хэргийн тодорхой хувийг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргүүд эзэлж байна. Гэтэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусах нь хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх эрх зүйн үндэслэл болохын хувьд эрх зүйн хийдэлтэй байдлаар хуульчлагдсан нь гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завших боломж бүрдүүлжээ. Нөгөөтээгүүр Эрүүгийн хууль нь хүний эрхийг хамгийн ихээр хязгаарладаг хууль болохын хувьд эрх зүйн хийдэлтэй, ойлгомжгүй, хоёрдмол утга бүхий зохицуулалтуудыг агуулах нь хүний эрхийг зөрчих, ял завших, гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулах, хуулийн заалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх буюу хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх боломжийг хязгаарлах гэх мэт олон сөрөг үр дагавар дагуулдаг. Үүний тод илрэл нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт юм. Хэдийгээр шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль практикт хэрэгжиж эхлээд дөрөв гаруй жил өнгөрч байгаа хэдий ч Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт нь өнөөдрийг хүртэл

практикт маргаантай, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт хэвээр байна. Түүнчлэн эрх зүйн хийдэлтэй буюу гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны хувьд хэдэн жилээр тоологдох нь маргаан бүхий гэмт хэргүүдийн хувьд практикт тухайн гэмт хэрэгт оногдуулж буй ялын дээд хэмжээнээс хамааруулан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж буй хэрэг юм. Энэ ч утгаараа эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт нь нэг талаас гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завших, нөгөө талаараа гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулах гэх мэт олон сөрөг нөлөөллийг үзүүлж байна.

### 3.3. ЭРХ ЗҮЙН ХИЙДЭЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас (хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд) нь хамааруулан тоолдог байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн, ялын доод болон дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулсан нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нэлээд ахиц дэвшил авчирсан нь сайшаалтай хэдий ч зарим гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагдсан. Тухайлбал, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд 209 төрлийн гэмт хэрэг хуульчлагдсанаас 83<sup>67</sup> гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй, ойлгомжгүй байдал үүсгээд байсан юм.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахдаа “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй.”<sup>68</sup>

- 1.1. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

<sup>67</sup> Дэлгэрэнгүйг Хүснэгт 3 болон 4-өөс үзнэ үү.

<sup>68</sup> Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

- 1.2. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж хуульчилсан нь эрх зүйн хийдэл бий болгосон.

Эрүүгийн хуульд хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн таван төрлийн ял оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял, бусад нь үндсэн ял билээ.<sup>69</sup> Гэтэл хууль тогтоогч хорих болон зорчих эрхийг хязгаарлах гэсэн хоёр төрлийн ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор 2015 онд хуульчилсан юм. Үүний улмаас Эрүүгийн хуулийг даган мөрдөж эхэлмэгц гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой хэд хэдэн асуудал үүссэн. Үүнийг товчхон дурдвал:

1. Торгох ялтай буюу хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн яаж тоолох нь хуульчлагдаагүй орхигдсон;
2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилдөн, эрх зүйн хийдэл бий болгосон;
3. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллыг үл харгалзан тогтоосон нь зарим хийдэл, зөрчил, ойлгомжгүй байдал үүсгэсэн, гэмт хэргийн ангиллыг ач холбогдолгүй болгосон;
4. Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн тухайн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл тоолох уу эсхүл анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох уу гэдэг нь эргэлзээтэй;

---

<sup>69</sup> Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг хуульчилсан.

5. Зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ? Түдгэлзүүлсэн ял дээр хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь зөв эсэх.

Өөрөөр хэлбэл, дээр дурдсан эргэлзээтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт, зохицуулагдаагүй үлдсэн асуудлын улмаас хүний эрх зөрчигдөх нөхцөл боломж бүрдсэн бөгөөд энэ мэтчилэн эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зорилго, ач холбогдлыг алдагдуулж байсан юм. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг нэмэлт, өөрчлөлт нь дээр дурдсан эрх зүйн хийдлийг арилгах, засаж сайжруулах боломж бүрдүүлсэн томоохон алхам болсон. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад оногдуулах хорих ялын доод хэмжээг гурван сар байхаар хуульчилсан байсан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “...зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар... хорих ялыг эдлүүлнэ” гэж заасантай зөрчилдөж байсныг тус нэмэлт, өөрчлөлтөөр засаж, эрх зүйн хийдлийг арилгасан. Мөн 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй” гэж заасан хэр нь тус зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно”<sup>70</sup> гэж ялгамжтай байдлаар хуульчилсан. Тус хоёр зохицуулалт нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл эсхүл гэмт хэрэг үйлдсэн хүнийг яллагдагчаар татах хүртэл тоолох мэт хоёр өөр агуулгыг илэрхийлж байсныг зассан.

Энэ мэтчилэн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн эрх зүйн хийдэл

<sup>70</sup> 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно” гэж хуульчилсан байсныг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.



бүхий зохицуулалтыг зарим талаараа засаж сайжруулах боломж бүрдүүлсэн ч нэмэлт, өөрчлөлт оруулсан зарим зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэхээр, олон салаа утга бүхий зохицуулалт агуулсаар байна.<sup>71</sup>

Иймд энэ хэсэгт 2015 оны Эрүүгийн хууль болон 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт дэх гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг харьцуулж<sup>72</sup> дараах асуудлыг дэвшүүлэн тавьж, судалсан болно.

**Асуудал 1.** 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан (Хүснэгт 3-т дурдсан) хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэргүүдийн хувьд ялын хэмжээгээр хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох вэ гэсэн асуудал бий болж байсан. Учир нь 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар хорих ялын доод хэмжээ нь нэг жил, дээд хэмжээ нь найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг таван жил байхаар хуульчилсан боловч дээрх гэмт хэргүүдийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ зургаан сараас эхэлж байсан нь тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалт нь хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ болох нэг жилд хүрэхгүй байхаар хуульчлагдсан. Өөрөөр хэлбэл, хорих ялын доод хэмжээ нэг жил хүрэхгүй байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байсан юм.

Мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаар хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэг жил байхаар тогтоосон. Гэтэл зарим гэмт хэргийн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээ зургаан сараас эхэлж байгаа ч ялын дээд хэмжээ нь тав хүртэл жил байгаа нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэг эсхүл таван жилийн аль хугацаагаар нь тоолох вэ гэсэн эргэлзээтэй байдал бий болгож байлаа.

Энэхүү асуудал нь Эрүүгийн хуульд эрх зүйн хийдэл бий болгож, зайлшгүй засаж сайжруулах шаардлагатай зохицуулалтын нэгд зүй

<sup>71</sup> Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-ын 51-53 дахь хэсгээс болон Хүснэгт 4-өөс үзнэ үү.

<sup>72</sup> Харьцуулалтыг Хавсралтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

ёсоор тооцогдох болсон. Тиймээс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтийг доорх хүснэгтэд тайлбарлалаа.

*Хүснэгт 3. Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай  
гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа<sup>73</sup>*

| № | 2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт |                  |                  | ТАЙЛБАР                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|---|---------------------------------------|------------------|------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | Зүйл, заалт                           | Ялын доод хэмжээ | Ялын дээд хэмжээ |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 1 | 10.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг       | 6 сар            | 3 жил            | 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй гэж нэмж хуульчилсан байна. |
| 2 | 11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг       | 6 сар            | 3 жил            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 3 | 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг       | 6 сар            | 3 жил            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 4 | 11.4 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт    | 6 сар            | 3 жил            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 5 | 11.7 дугаар зүйлийн 2.3 дахь заалт    | 6 сар            | 2 жил            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 6 | 12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг       | 6 сар            | 2 жил            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |

<sup>73</sup> Г.Халиунаа, Б.Ариунжаргал (2020), Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №2, 222-230 дахь тал.

## Хүснэгт 3-ын үргэлжлэл

|    |                                          |       |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|----|------------------------------------------|-------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7  | 12.5 дугаар<br>зүйлийн 2.2<br>дахь заалт | 6 сар | 3 жил | Ийнхүү тус заалт Эрүүгийн хуульд орсноор 1 эсхүл 5 жилийн алинаар нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь эргэлзээ үүсгээд байсан 53 зохицуулалтын 50 зохицуулалтад 3 жилийн хугацаагаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломж бүрдүүлсэн юм.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 8  | 13.4 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 9  | 14.8 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 10 | 15.1 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 3 жил | Энэхүү эрх зүйн хийдэл бүхий 53 хэргээс онцлог нэг хэргийг тусгайлан тайлбарлавал, 2015 оны Эрүүгийн хуульд заасан хорих ялгүй, зорчих эрхийг хязгаарлах ялтай нийт 48 хэрэг байснаас гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй нэг хэрэг байсан нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэрэг юм. Учир нь тус хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ...” гэж заасан. Өөрөөр хэлбэл, энэхүү зохицуулалт нь 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 болон 1.2 дахь заалтын аль алинд нь хамаардаггүй байсан юм. |
| 11 | 17.3 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 12 | 17.4 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 13 | 17.5 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 14 | 17.8 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 15 | 18.2 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 16 | 18.4 дүгээр<br>зүйлийн 2.2<br>дахь заалт | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 17 | 18.8 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |

## Хүснэгт 3-ын үргэлжлэл

|    |                                           |       |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|----|-------------------------------------------|-------|-------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 18 | 18.9 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг     | 6 сар | 2 жил | Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” гэсэн заалт нэмж хуульчилснаар тус зохицуулалтад тоолох хөөн хэлэлцэх хугацаа гурван жил болсон юм. |
| 19 | 18.13 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 20 | 18.16 дугаар<br>зүйлийн 2.2<br>дахь заалт | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 21 | 19.11 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 22 | 19.13 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 23 | 19.14 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 24 | 19.15 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 25 | 19.15 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 26 | 19.16 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 27 | 19.17 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 2 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 28 | 20.14 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

*Хүснэгт 3-ын үргэлжлэл*

|    |                                        |       |       |
|----|----------------------------------------|-------|-------|
| 29 | 21.1 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг  | 6 сар | 2 жил |
| 30 | 21.9 дүгээр<br>зүйлийн 2<br>дахь хэсэг | 6 сар | 3 жил |
| 31 | 21.11 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг | 6 сар | 3 жил |
| 32 | 22.4 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг  | 6 сар | 3 жил |
| 33 | 22.4 дүгээр<br>зүйлийн 3<br>дахь хэсэг | 6 сар | 3 жил |
| 34 | 22.5 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг  | 6 сар | 3 жил |
| 35 | 22.10 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг | 6 сар | 3 жил |
| 36 | 22.11 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг | 6 сар | 3 жил |
| 37 | 22.12 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг | 6 сар | 3 жил |
| 38 | 23.1 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг  | 6 сар | 3 жил |
| 39 | 23.2 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг | 6 сар | 3 жил |

## Хүснэгт 3-ын үргэлжлэл

|    |                                          |       |       |
|----|------------------------------------------|-------|-------|
| 40 | 23.4 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |
| 41 | 23.5 дугаар<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 2 жил |
| 42 | 25.1 дүгээр<br>зүйлийн 2<br>дахь хэсэг   | 6 сар | 3 жил |
| 43 | 25.3 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |
| 44 | 25.4 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |
| 45 | 25.6 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 3 жил |
| 46 | 26.1 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 2 жил |
| 47 | 27.7 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 2 жил |
| 48 | 27.10 дугаар<br>зүйлийн 2.4<br>дэх заалт | 6 сар | 3 жил |
| 48 | 28.10 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг   | 6 сар | 2 жил |

## Хүснэгт 3-ын үргэлжлэл

|    |                                          |       |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----|------------------------------------------|-------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 50 | 13.5 дугаар<br>зүйлийн 2.2<br>дахь заалт | 3 сар | 2 жил | Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад оногдуулах хорих ялын доод хэмжээг 3 сар байхаар хуульчилж өгсөн байсан нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "... зургаан сараас хорин жил хүртэл хугацаагаар... хорих ялыг эдлүүлнэ" гэж заасантай зөрчилдөж байсныг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж хорих ялын доод хэмжээг зургаан сар болгон ЭХЕА-ийн зохицуулалтад нийцүүлсэн байна. |
| 51 | 17.1 дүгээр<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 5 жил | Энэхүү гурван зохицуулалтын хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь нэг эсхүл таван жилийн аль алинд нь хамаарахгүй хэвээр байгаа юм.                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 52 | 17.2 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг    | 6 сар | 5 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 53 | 17.12 дугаар<br>зүйлийн 1 дэх<br>хэсэг   | 6 сар | 5 жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |

Энэ мэтчилэн тус нэмэлт, өөрчлөлтөөр эрх зүйн хийдэл бүхий хэд хэдэн асуудлыг засаж сайжруулах боломж бүрдүүлсэн ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй хэвээр байгаа юм.

Учир нь эдгээр зохицуулалт нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад заасан “...хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон...” гэсэн заалтад мөн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон” гэж нэмж хуульчилсан заалтад ч хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх гурван зохицуулалт нь одоог хүртэл эрх зүйн хийдэлтэй хэвээр байна.

**Асуудал 2.** Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуульд бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй” хэмээн хуульчилсан. Тус зохицуулалтын дагуу гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэмт хэргүүд нь:

1. 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
2. 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
3. 12.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;
4. 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,
5. 19.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг;
6. 19.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;
7. 19.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
8. 19.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг;
9. 19.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;
10. 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг;<sup>74</sup>
11. 29.1 дүгээр бүлгийн гэмт хэргүүд.

<sup>74</sup> 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмсэн.



Нийт зургаан бүлгийн 21 гэмт хэрэгт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар зохицуулснаас 15 гэмт хэрэг нь бүх насаар нь хорих ял оногдуулах ялтай, зургаан гэмт хэрэг нь бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй ч 29 дүгээр бүлэгт<sup>75</sup> заасан гэмт хэрэг байна. Үүнээс үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор байна. Гэтэл 2015 онд Эрүүгийн хуулийн зургаан бүлгийн 30 зүйл, заалтад зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан. Харин тус хуульд хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын хэмжээнээс хамааруулан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчилж өгсөн учир торгох ял<sup>76</sup> оногдуулахаар заасан хэргүүдэд хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь ойлгомжгүй байсан юм.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэж нэмж хуульчилснаар зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан хэргүүд буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан заалтуудад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломж бүрдүүлсэн.

<sup>75</sup> Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргүүд хуульчлагдсан.

<sup>76</sup> Зөвхөн торгох ялтай гэмт хэргүүдийн хувьд 10.000-80.000, 20.000-100.000, 20.000-120.000, 40.000-200.000, 120.000-400.000, 200.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээгээр торгох ял оногдуулахаар хуульчилсан байна.

*Хүснэгт 4. Торгох ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх  
хугацааг хэрхэн тоолохыг хуульчилсан жишээ<sup>77</sup>*

| № | Зүйл, заалт                         | Торгох<br>ялын<br>хэмжээ<br>(нэгжээр) | Хөөн хэлэлцэх хугацаа<br>(2020 оны 1 дүгээр сарын<br>10-ны өдрийн нэмэлт,<br>өөрчлөлт) |                                                                                                                                     |
|---|-------------------------------------|---------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                                     |                                       | Тухайн<br>зүйлийн 1<br>дэх хэсэгт<br>заасантай<br>ижил<br>хугацаагаар<br>тогтоовол     | Хуулийн<br>этгээдэд<br>хариуцлага<br>хүлээлгэхээр<br>заасан заалтын<br>дээд хэсэгт<br>заасантай<br>ижил<br>хугацаагаар<br>тогтоовол |
| 1 | 18.1 дүгээр зүйлийн<br>2 дахь хэсэг | 10.000-<br>80.000                     | 1 жил                                                                                  | 1 жил                                                                                                                               |
| 2 | 18.2 дугаар зүйлийн<br>3 дахь хэсэг | 20.000-<br>120.000                    | 3 жил                                                                                  | 5 жил                                                                                                                               |
| 3 | 18.5 дугаар зүйлийн<br>5 дахь хэсэг | 200.000-<br>400.000                   | 1 жил                                                                                  | 12 жил                                                                                                                              |
| 4 | 18.6 дугаар зүйлийн<br>4 дэх хэсэг  | 100.000-<br>400.000                   | 1 жил                                                                                  | 12 жил                                                                                                                              |
| 5 | 18.7 дугаар зүйлийн<br>4 дэх хэсэг  | 100.000-<br>400.000                   | 5 жил                                                                                  | 12 жил                                                                                                                              |
| 6 | 18.8 дугаар зүйлийн<br>4 дэх хэсэг  | 10.000-<br>80.000                     | 3 жил                                                                                  | 12 жил                                                                                                                              |
| 7 | 18.9 дүгээр зүйлийн<br>4 дэх хэсэг  | 10.000-<br>80.000                     | 3 жил                                                                                  | 12 жил                                                                                                                              |

<sup>77</sup> Г.Халиунаа, Б.Ариунжаргал (2020), Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, №2, 222-230 дахь тал.

*Хүснэгт 4-ийн үргэлжлэл*

|    |                                         |                     |       |        |
|----|-----------------------------------------|---------------------|-------|--------|
| 8  | 18.10 дугаар<br>зүйлийн 3 дахь<br>хэсэг | 10.000-<br>80.000   | 1 жил | 1 жил  |
| 9  | 18.13 дугаар<br>зүйлийн 4 дэх хэсэг     | 10.000-<br>80.000   | 3 жил | 5 жил  |
| 10 | 20.7 дугаар зүйлийн<br>4 дэх хэсэг      | 40.000-<br>200.000  | 5 жил | 20 жил |
| 11 | 20.10 дугаар<br>зүйлийн 3 дахь<br>хэсэг | 40.000-<br>200.000  | 5 жил | 12 жил |
| 12 | 20.11 дүгээр<br>зүйлийн 3 дахь<br>хэсэг | 20.000-<br>120.000  | 5 жил | 5 жил  |
| 13 | 20.11 дүгээр<br>зүйлийн 4 дэх хэсэг     | 200.000-<br>400.000 | 5 жил | 5 жил  |
| 14 | 20.12 дугаар<br>зүйлийн 3 дахь<br>хэсэг | 10.000-<br>80.000   | 5 жил | 5 жил  |
| 15 | 20.12 дугаар<br>зүйлийн 4 дэх хэсэг     | 20.000-<br>120.000  | 5 жил | 5 жил  |
| 16 | 20.13 дугаар<br>зүйлийн 2 дахь<br>хэсэг | 20.000-<br>120.000  | 5 жил | 5 жил  |
| 17 | 20.14 дүгээр<br>зүйлийн 4 дэх хэсэг     | 20.000-<br>120.000  | 3 жил | 5 жил  |
| 18 | 20.14 дүгээр<br>зүйлийн 5 дахь<br>хэсэг | 200.000-<br>400.000 | 3 жил | 5 жил  |
| 19 | 22.5 дугаар зүйлийн<br>3 дахь хэсэг     | 120.000-<br>400.000 | 3 жил | 5 жил  |

## Хүснэгт 4-ийн үргэлжлэл

|    |                                     |                     |        |        |
|----|-------------------------------------|---------------------|--------|--------|
| 20 | 24.1 дүгээр зүйлийн<br>3 дахь хэсэг | 20.000-<br>120.000  | 5 жил  | 5 жил  |
| 21 | 24.1 дүгээр зүйлийн<br>4 дэх хэсэг  | 40.000-<br>200.000  | 5 жил  | 5 жил  |
| 22 | 24.2 дугаар зүйлийн<br>3 дахь хэсэг | 20.000-<br>120.000  | 5 жил  | 5 жил  |
| 23 | 24.2 дугаар зүйлийн<br>4 дэх хэсэг  | 120.000-<br>400.000 | 5 жил  | 5 жил  |
| 24 | 24.3 дугаар зүйлийн<br>3 дахь хэсэг | 20.000-<br>120.000  | 5 жил  | 5 жил  |
| 25 | 24.3 дугаар зүйлийн<br>4 дэх хэсэг  | 40.000-<br>200.000  | 5 жил  | 5 жил  |
| 26 | 24.4 дүгээр зүйлийн<br>2 дахь хэсэг | 120.000-<br>400.000 | 12 жил | 12 жил |
| 27 | 24.6 дугаар зүйлийн<br>3 дахь хэсэг | 20.000-<br>120.000  | 1 жил  | 5 жил  |
| 28 | 24.9 дүгээр зүйлийн<br>2 дахь хэсэг | 120.000-<br>400.000 | 12 жил | 12 жил |
| 29 | 25.2 дугаар зүйлийн<br>3 дахь хэсэг | 10.000-<br>80.000   | 1 жил  | 5 жил  |
| 30 | 25.4 дүгээр зүйлийн<br>3 дахь хэсэг | 10.000-<br>80.000   | 3 жил  | 5 жил  |

Гэсэн хэдий ч тус зохицуулалт хэд хэдэн асуудал бий болгож байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно...” гэж заасан. Гэтэл энэхүү заалтыг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэж болохоор байгаа юм. Тухайлбал, тус хуулийн 18.7 дугаар зүйл гэхэд дөрвөн хэсгээс бүрдэж байна. 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3-т

заасан зохицуулалтад зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар заасан тул хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Тэгвэл хуулийн этгээд нь 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боловч тухайн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн яг аль хэсгээр тоолох нь ойлгомжгүй. Өөрөөр хэлбэл, тухайн зүйл, хэсэгт гэдгийг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 гэж гурван янзаар тайлбарлан ойлгож болохоор байна. Үүнийг дэлгэрүүлэн Хүснэгт 5-д харуулав.

*Хүснэгт 5. Эрүүгийн хуулийн 18.7 дугаар зүйл*

| № | Зүйл, заалт                      | Торгох ялын хэмжээ  | Хорих ялын хэмжээ |
|---|----------------------------------|---------------------|-------------------|
| 1 | 18.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг  | 5.400.000-7.000.000 | 1-5 жил           |
| 2 | 18.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг | -                   | 2-8 жил           |
| 3 | 18.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг | -                   | 5-12 жил          |

Гэтэл оногдуулж буй ялын хувьд энэ гурван зохицуулалт өөр хоорондоо ялгаатай байгаа юм.

2. Хэрэв тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дараах асуудал үүсэж болохоор байна:
  - Торгох ялын хэмжээ ижил хэр нь хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10,000-80,000 нэгжийн торгох ялтай найман<sup>78</sup> хэргийн

<sup>78</sup> Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг.

хувьд гурван хэрэгт нь нэг жил, дөрвөн хэрэгт нь гурван жил, нэг хэрэгт нь таван жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор байгаа юм.

- Торгох ялын хэмжээ нь бага хэдий ч хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна.
  - Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм.
  - Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт тоолох гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа богино байх асуудлыг үүсгэж болохоор байна.
3. Хэрэв 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан байвал 18.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолох буюу тухайн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх заалтын дээд талын хэсэгт заасан хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дор дурдсан асуудлууд үүсэхээр байна:
- Торгох ялын хэмжээ ижил хэр нь хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10,000-80,000 нэгжийн торгох ялтай найман хэргийн хувьд хоёр хэрэгт нь нэг жил, дөрвөн хэрэгт нь таван жил, хоёр хэрэгт нь 12 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор байгаа юм.
  - Торгох ялын хэмжээ бага хэр нь хөөн хэлэлцэх хугацаа бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна. Жишээ нь, Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 40,000-120,000 нэгжээр торгох ялтай хэр нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 20 жил байгаа бол мөн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 200,000-400,000 нэгжээр торгохоор заасан боловч хөөн хэлэлцэх хугацаа нь таван жил байна.

- Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэр нь хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг.


Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох асуудал одоогоор практикт үүсээгүй гэж үзэж болохоор байна. Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийхэд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хуулийн этгээдэд хариуцлага тооцох боломжгүй гэж шийдвэрлэсэн нэг кейс<sup>79</sup> байна. Энэ гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэг бөгөөд прокурор тус зүйлийн 3 дахь хэсгээр зүйлчилж шүүхэд ирүүлснийг шүүх Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийг удирдлага болгон хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Уг гэмт хэргийн тухайд хөөн хэлэлцэх хугацаа тоолоход хүндрэл бэрхшээл учраагүй байна. Учир нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хэмжээ 1-5 жил хүртэл, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн бол” гэх зохицуулалтад хоёул хамаарагдах тул тус гэмт хэргийн тухайд дээр дурдсан ойлгомжгүй байдал үүсээгүй ажээ.

Мөн эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны 68 шүүгчээс “2020 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор хуульчилсан. Энэхүү зохицуулалтын талаар Таны бодол ямар байна вэ?

<sup>79</sup> Шүүхийн шийдвэрийн цахим сан.  
<http://new.shuukh.mn/eruuhanhan/27256/view>

Уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд ямар нэг хүндрэлтэй байдал үүсэж (үүсэхээр) байна уу?” гэсэн асуулга авахад дараах үр дүн гарсан юм.

График 3. Эрүүгийн хэргийн шүүгчдээс авсан асуулга



Асуулгад хамрагдсан нийт 68 шүүгчээс 54 нь буюу 79.4 хувь нь тодорхой саналгүй эсхүл асуулгад хариулаагүй бол энэ гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцох нь буруу гэж зургаан хувь нь, хөөн хэлэлцэх хугацааг уртасгах шаардлагатай гэж гурван хувь нь үзжээ. Оролцогчдын дийлэнх нь тодорхой саналгүй байгаа нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн практик байхгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Учир нь асуулгын явцад хэд хэдэн шүүгч “Ийм хэрэг шийдвэрлэсэн практик байхгүй тул сайн хэлж мэдэхгүй байна” гэж тэмдэглэжээ.

**Асуудал 3.** 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа...” гэсэн нэр томьёо хэрэглэжээ. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд тус зохицуулалтыг “...гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа...” гэж хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, дээрх нэр томьёо нь нэг утга санааг илэрхийлж байгаа хэдий ч ялгамжтай байдлаар хуульчлагдсаныг нэг мөр болгох нь зүйтэй.



**Асуудал 4.** 2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолохдоо гэмт хэргийн ангиллаас хамааруулан тоолдог байсан. Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зорчих болон хорих ялын дээд, доод хэмжээнээс хамааруулан тоолохоор хуульчилсан билээ. Ийнхүү гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллыг үл харгалзан тогтоосон нь гэмт хэргийн ангиллыг ач холбогдолгүй болгосон гэж зарим талаар дүгнэж болохоор байна. Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлд:

- “1. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.
2. Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” гэж зааснаас үзвэл гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж хоёр ангилжээ. Хэдийгээр энэ хуульд гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж ангилсан боловч гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хүнд, хөнгөн гэмт хэргийн хувьд адил тоологдохоор хэд хэдэн гэмт хэрэг эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчлагдсан байна.

Учир нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад “...Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн...” гэж заасан нь хөнгөн, хүнд гэмт хэрэгт аль алинд нь хамаарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, хөнгөн гэмт хэрэг, хүнд гэмт хэрэгт ижил хугацаагаар хөөн хэлэлцэх хугацаа тоолж байгаа нь гэмт хэргийн ангиллыг үгүйсгэсэн байж болохоор байна. Хөнгөн, хүнд гэмт хэргийн ангиллыг үгүйсгэсэн нийт 175 гэмт хэрэг байна.

*Хүснэгт 6. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг  
хөнгөн, хүнд гэмт хэргэд ижил тоолохоор хуульчилсан жишээ*

| Хөнгөн гэмт хэрэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Хүнд гэмт хэрэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>10.2 дугаар зүйл.<br/>Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах<br/>1. Өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хүндээр доромжлогдсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүнийг алсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<br/>/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p> | <p>10.3 дугаар зүйл.<br/>Баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлж хүнийг алах<br/>1. Гэмт хэрэг үйлдсэн хүн, оргосон ялтныг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор халдахдаа тухайн хүний үйлдсэн гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохирохгүй үйлдэл хийж; тухайн хүнд зайлшгүй хохирол учруулж саатуулах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад халдаж алсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> | <p>Эдгээр гэмт хэргийн хувьд хөнгөн болон хүнд гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацаа ижилхэн байна. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т заасны дагуу “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэсэн байдлаар хөөн хэлэлцэх хугацааг хуульчилж өгсөн нь хөнгөн болон хүнд гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нь адилхан таван жил байх нөхцөл бүрдүүлсэн байна.</p> |

|                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 10.6 дугаар зүйл.<br>Хүний амь насыг<br>болгоомжгүйгээр<br>хохироох                                                                                         | 10.4 дүгээр зүйл.<br>Хүнийг амиа хорлох<br>нөхцөл байдалд<br>хүргэх                                                                                                                                                                                                                                                                                          |
| 2. Энэ гэмт хэргийн<br>улмаас хоёр, түүнээс<br>олон хүний амь насыг<br>хохироосон бол хоёр<br>жилээс найман жил<br>хүртэл хугацаагаар<br>хорих ял шийтгэнэ. | 1. Эд хөрөнгө, албан<br>тушаал, гэр бүлийн<br>хамаарал бүхий<br>харилцаа, бусад<br>нөхцөл байдлын<br>улмаас эрхшээлдээ<br>байгаа хүнийг байнга<br>хүчирхийлсэн,<br>доромжилсон, зодсон,<br>тамлан зовоосон,<br>айлган сүрдүүлсний<br>улмаас амиа хорлоход<br>гарцаагүй хүргэсэн<br>бол хоёр жилээс<br>найман жил хүртэл<br>хугацаагаар хорих ял<br>шийтгэнэ. |

## ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл буюу гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтад хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж заасныг тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Зөрчлийн тухай хуультай уялдуулан “...Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно...” гэж өөрчлөн найруулсан нь тус зохицуулалтын эрх зүйн хийдлийг арилган, уялдаа холбоог хангасан өөрчлөлт болсон байна.

Мөн Эрүүгийн хуульд 1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг нэмж хуульчилсан нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэг эсхүл таван жилийн хугацаагаар тоолохоор хуульчлагдсан заалтад аль алинд нь хамаарч байсан нийт 53 заалтаас 50 заалтад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гурван жилээр тоолох боломж бүрдүүлсэн юм. Гэсэн хэдий ч тус хуулийн гурван заалтын хөөн хэлэлцэх хугацаа нэг эсхүл таван жилийн аль алинд нь хамаарч байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн торгох ял оногдуулахаар заасан буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар зохицуулалтгүй байсныг засаж сайжруулахыг зорьсон боловч тус зохицуулалт нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар эргэлзээтэй байдал бий болгосон хэвээр байна.

# ДӨРӨВ. ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГТ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ ЯЛГАМЖТАЙ БАЙДЛААР ЗОХИЦУУЛАХЫН УЧИР ХОЛБОГДОЛ

Судалгааны энэ хэсэгт олон улсын эрх зүйн баримт бичгийн хүрээнд тодорхой төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тооцдог эсэх болон үүнийг манай улс хууль тогтоомждоо хэрхэн тусгасан, мөн зарим төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх явцад тулгамдаж буй асуудлын талаар хөндөхийг хичээлээ.

## 4.1. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ БА МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

### Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм

Дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйд баримталдаг олон улсын баримт бичгийн нэг бол “Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм”<sup>80</sup> юм. Энэхүү дүрэм нь 1998 оны 7 дугаар сарын 18-ны өдөр батлагдаж, 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх болсон.<sup>81</sup> Тус конвенцын 29 дүгээр зүйлд хөөн хэлэлцэх хугацааг үл хэрэглэх зохицуулалтыг “Шүүхээс хэрэг шүүн шийдвэрлэхэд хамаарах гэмт хэргийн хувьд ямар ч хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй”<sup>82</sup> хэмээн тусгажээ.

<sup>80</sup> Уг конвенцод Монгол Улс 2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр нэгдэн орсон.

<sup>81</sup> Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээ, конвенц.  
<http://vienna.embassy.mn/index.php?moduls=15>

<sup>82</sup> Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм.  
<https://legalinfo.mn/law/details/1217?lawid=1217&sword>

## Дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 1968 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенц”<sup>83</sup> баталж, 1970 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.<sup>84</sup>

Манай улсын хувьд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй”<sup>85</sup> гэж заажээ. Энэ нь тус конвенцод нэгдэн орсон орны хувьд дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, учруулж буй хохирол, хор уршиг асар их учир ийнхүү гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар хуульчилжээ. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 29 дүгээр бүлэгт хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг 11 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна.<sup>86</sup>

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн улс орны хүн ам, эдийн засаг, нийгмийн олон талт харилцаанд үзүүлэх сөрөг нөлөө, уг гэмт хэргийн улмаас үүсэж буй хохирол, хор уршиг асар их байдаг. Иймд НҮБ-аас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”<sup>87</sup>-ыг 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ.<sup>88</sup> Энэхүү конвенцын “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлага” хэмээх 3 дугаар зүйлийн 8-д “Тал бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт эрүүгийн журмаар мөрдөх ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацааг

<sup>83</sup> Уг конвенцод Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 21-ний өдөр нэгдэн орсон.

<sup>84</sup> Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээ, конвенц.  
<http://vienna.embassy.mn/index.php?moduls=15>

<sup>85</sup> Эрүүгийн хууль (2016), “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, №7.

<sup>86</sup> Мөн тэнд.

<sup>87</sup> Уг конвенцод Монгол Улс 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр нэгдэн орсон.  
<http://vienna.embassy.mn/index.php?moduls=15>

<sup>88</sup> Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц.  
[https://www.legalinfo.mn/law/?cat=29&l\\_name=%D0%9C](https://www.legalinfo.mn/law/?cat=29&l_name=%D0%9C)

шаардлагатай тохиолдолд дотоодынхоо хуулийн дагуу урт хугацаагаар тогтоох болон сэжигтэн этгээд шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн тохиолдолд илүү урт хугацаагаар тогтооно”<sup>89</sup> гэж заажээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дээр дурдсан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргээс гадна бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар хуульчилсан. Тус хуульд бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан хэргүүдийг судлан Хүснэгт 7-д харуулав.

*Хүснэгт 7. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд  
бүх насаар хорих ял оногдуулахаар заасан хэргүүд*

| № | Зүйлийн нэр                                                                                   | Зүйл, заалт                      |
|---|-----------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|
| 1 | 10.1 дүгээр зүйл. Хүнийг алах                                                                 | 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг |
| 2 | 12.1 дүгээр зүйл. Хүчиндэх                                                                    | 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг  |
| 3 | 12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг                                                             | 12.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг  |
| 4 | 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах                                                             | 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг |
| 5 | 19.1 дүгээр зүйл. Эх орноосоо урвах                                                           | 19.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг  |
| 6 | 19.3 дугаар зүйл. Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах                                | 19.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг |
| 7 | 19.4 дүгээр зүйл. Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах | 19.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг |

<sup>89</sup> Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц.  
<https://legalinfo.mn/law/details/1239?lawid=1239>

## Хүснэгт 7-гийн үргэлжлэл

|    |                                                                                 |                                                                                       |
|----|---------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|
| 8  | 19.5 дугаар зүйл. Зэвсэгт үймээн дэгдээх                                        | 19.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                                                       |
| 9  | 19.6 дугаар зүйл. Хорлон сүйтгэх                                                | 19.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг                                                      |
| 10 | 20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах | 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг (2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн) |

Дээрх хүснэгтээс үзвэл 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэргийг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ” гэж шинээр нэмж тусгажээ. Хуулийн энэхүү зохицуулалтаас харахад энэ төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар хуульчлагдсан нь олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенцын заалтыг дотоодын хууль тогтоомждоо бүрэн утгаар нь тусгасан гэж үзэж болохоор байна.

#### 4.2. ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААГ НЬ ЯЛГАМЖТАЙ БАЙДЛААР ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ГЭМТ ХЭРГҮҮД

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай зохицуулах шаардлагатай гэмт хэргүүд байдаг. Энэ нь тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайван хийгээд тухайн улс орны аюулгүй байдал, улс төр, эдийн засаг, нийгмийн олон талт харилцаанд сөргөөр нөлөөлдөг, мөн хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөнд халдаж, нөхөж баршгүй их хэмжээний хохирол, хор уршиг учруулж байдагтай шууд хамааралтай. Энэ ч утгаараа гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай байдлаар зохицуулах шаардлагатай зарим төрлийн гэмт хэргийг товчхон судалж үзсэн болно.



### Авлигын гэмт хэрэг

Авлига нь төрийн тогтвортой байдал, нийгмийн аюулгүй байдалд аюул занал учруулж ардчилсан тогтолцоо, нийгмийн үнэт зүйлс, ёс суртахууны эрхэм чанарыг үнэгүйдүүлж, хууль дээдлэх ёсыг аажмаар устгаж байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, үүний эсрэг тууштай тэмцэх аргыг эрэлхийлж зөвхөн үндэсний хэмжээнд биш олон улсад мөрдөгдөх хэм хэмжээг тогтоосны нэг нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталж, 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн<sup>90</sup> Авлигын эсрэг НҮБ-ын конвенц<sup>91</sup> юм.

Тус конвенцын “Хөөн хэлэлцэх хугацаа” хэмээх 29 дүгээр зүйлд “Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу зохих тохиолдолд энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэрэгт хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоож, сэжигтэн этгээд шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн бол хөөн хэлэлцэх хугацааг илүү уртаар тогтоох буюу хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэхээр заана”<sup>92</sup> гэж тусгажээ. Энэхүү зохицуулалтаас үзвэл авлигын гэмт хэрэг нь зарим хэрэгтэй харьцуулахад улс орны хөгжил, эрх зүйт төрийн бодлого, улс төр, эдийн засаг, хууль эрх зүй хийгээд нийгмийн бүхий л харилцаанд сөргөөр нөлөөлж, асар их хохирол, хор уршиг бий болгож байдагтай холбоотой.

Түүнчлэн авлигын гэмт хэргийг илрүүлэхэд хүндрэлтэй, нуугдмал гэмт хэрэг гэж үзэж болох юм. Энэ ч утгаараа өндөр түвшний авлига нь хэдэн арван жилийн дараа ил болох, зарим тохиолдолд ил болохгүй байх ч магадлалтай. Гэтэл тухайн авлигын гэмт хэргийн улмаас улс оронд асар их хохирол, хор уршиг учирсан ч Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг богино тогтоосон тохиолдолд авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломж хязгаарлагдах юм. Энэ ч утгаараа Авлигын эсрэг

<sup>90</sup> Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээ, конвенц.  
<http://vienna.embassy.mn/index.php?moduls=15>

<sup>91</sup> Авлигын эсрэг конвенцод Монгол Улс 2005 онд нэгдэн орсон бөгөөд уг баримт бичгийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн.

<sup>92</sup> Авлигын эсрэг НҮБ-ын конвенц.  
<https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>

НҮБ-ын конвенцод тус гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг бусад гэмт хэргээс илүү урт хугацаагаар тогтоохоор онцгойлон заажээ.

Манай улсын хувьд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэгт авлигын гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон хуульчилсан билээ. Ийнхүү бүлэг болгон хуульчилсан нь нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон хохирлын хэмжээнээс үл хамааран гэмт хэрэгт тооцож, ял оногдуулах, мөн гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах болон гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах гэмт хэргийг шинээр гэмт хэрэгт тооцохоор заасан нь энэхүү хуулийн давуу талыг илэрхийлж байна.

Манай улсын хувьд авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохтой холбоотой 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэхэд томоохон маргаан үүсээд байгаа билээ. Тус хуульд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд буюу хоёр жил зургаан сарын хугацаанд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгах аар тусгаснаас гадна тухайн үед мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй гэж хуульчилжээ.

Энэ хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг нь Авлигын гэмт хэрэг бөгөөд тус хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь оногдуулж буй хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын дээд, доод хэмжээнээс хамаарч 3-12 жил хүртэл байна. Гэхдээ гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа 12 жил байхаар тогтоосон заалт нь Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 22.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хоёр зохицуулалтад л хамаарч байна.

*Хүснэгт 8. Авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа<sup>93</sup>*

| № | Зүйл, заалт                                                                                                                                               | Хөөн хэлэлцэх хугацаа                                     |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|
| 1 | 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах<br>22.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг                                            | 5 жил                                                     |
| 2 | 22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах<br>22.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг | 5 жил                                                     |
| 3 | 22.4 дүгээр зүйл. Хахууль авах<br>22.4 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг                                                                                     | 3 жил                                                     |
| 4 | 22.4 дүгээр зүйл. Хахууль авах<br>22.4 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг                                                                                  | 5 жил                                                     |
| 5 | 22.4 дүгээр зүйл. Хахууль авах<br>22.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг                                                                                        | 12 жил                                                    |
| 6 | 22.5 дугаар зүйл. Хахууль өгөх<br>22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                                                                                         | 3 жил                                                     |
| 7 | 22.5 дугаар зүйл. Хахууль өгөх<br>22.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг                                                                                        | 5 жил                                                     |
| 8 | 22.5 дугаар зүйл. Хахууль өгөх<br>22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг                                                                                        | Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. |
| 9 | 22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах<br>22.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                 | 12 жил                                                    |

<sup>93</sup> 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон байдлаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тооцсон болно.

## Хүснэгт 8-ын үргэлжлэл

|    |                                                                                                                                            |       |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 10 | 22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах<br>22.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг | 5 жил |
| 11 | 22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх<br>22.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                                      | 5 жил |
| 12 | 22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах<br>22.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг                                    | 5 жил |
| 13 | 22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах<br>22.9 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг                  | 5 жил |
| 14 | 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих<br>22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                                                          | 3 жил |
| 15 | 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих<br>22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг                                                         | 5 жил |
| 16 | 22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах<br>22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг                                                                     | 3 жил |
| 17 | 22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах<br>22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг                                      | 3 жил |

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга үйлчилж эхэлснээс хойш авлигын хэд хэдэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд энэ нь тус гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа харьцангуй багаар (ихэнх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг 3-5 жилээр тоолохоор) хуульчлагдсантай холбоотой юм. Хууль санаачлагчид үүнтэй холбогдуулан "...авлига, албан тушаалын гэмт хэрэг нь улс орон, олон нийтийн эрх ашгийг хохироож, бусдад давуу байдал олгож хүнд хор хохирол учруулж байдаг

гэмт хэрэг тул ...Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлгийн гэмт хэргийг сэргээн шалгах нь зүйтэй гэж үзэн...”<sup>94</sup> 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлан, дагаж мөрдөх болсон байна. Тус хуулийн 1, 2 дугаар зүйлд “2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийг сэргээн шалгах аар...” тусгажээ.

Энэ нь эргээд “...Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх нэрийн дор ардчилсан улс орнуудын болон эрх зүйн түүхэнд байдаггүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргүүдийг сэргээх зохицуулалтыг хуульчилж, хүний эрхэд эрх зүйн бусаар халдах боломж бий болгосноор эрх зүйн суурь зарчмыг зөрчиж, хүний эрхэд хууль бусаар халдаж байна”<sup>95</sup> гэсэн үндэслэлээр Үндсэн хууль зөрчиж байна гэсэн асуудал үүсгэн Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсэхэд хүргэсэн юм.<sup>96</sup>

<sup>94</sup> Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар.

<https://www.legalinfo.mn/law/details/15812?lawid=15812>

<sup>95</sup> Нийслэлийн Баянгол дүүргийн 12 дугаар хорооны оршин суугч, иргэн Х.Сэлэнгэ Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэл.

<sup>96</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн дугаар 01 тогтоол. Х.Сэлэнгийн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээллээс.

<https://legalinfo.mn/law/details/16628?lawid=16628>

Ийнхүү гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болсон хэргийг сэргээн шалгах боломжтой эсэхийг онол, практикийн үүднээс доктор, профессор Х.Сэлэнгэ судлан үзсэн бөгөөд тэрээр эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүхэнд Эрүүгийн хуульд тусгагдсан хөөн хэлэлцэх хугацааны дагуу хэрэгсэхгүй болгосон ямар ч хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэсэн туршлага, онол, практик байхгүй байна. Энэ үндсэнд аливаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь Эрүүгийн хуульд заагдсан тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээнээс хамаарч тогтоогддог нийтлэг шинж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн хүрээнд парламентаас баталсан хүчин төгөлдөр хуулийн зүйл, заалтыг үндэслэл болгож, шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эрх

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийн үндэслэл хэсэгтээ “...тухайн хуулиар зөвхөн тодорхой төрлийн гэмт хэргийг буюу Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгахаар тусгасан нь Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг бүрдүүлсэн байна. Ийнхүү Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой төрлийн гэмт хэргийг тухайлан зааж өөр журам тогтоосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эрх тэгш байх зарчмыг хууль батлах замаар зөрчих буруу жишиг тогтох үр дагавартайг дурдах нь зүйтэй юм...” гэжээ. Мөн Цэцийн тус дүгнэлтэд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөний зэрэгцээ эрх зүйн суурь онолд нийцээгүй хэмээн үзжээ.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн их суудлын хуралдаанаар “...Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн

---

аль ч улс орны хууль тогтоох байгууллагад байхгүй юм. Мөн харьцуулсан эрх зүй судлалын үүднээс эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжил болон улс орнуудын Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулийг судалж үзэхэд хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгосон хэргийг буцаан сэргээх, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон заалт нэг ч байхгүй байна. Улс орнууд Эрүүгийн хуульдаа хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхэлж, хэзээ зогсох болон түдгэлзэх, хэзээ дуусах, ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулж байна. Мөн аль ч улс оронд хууль тогтоох байгууллагаас баталсан хүчин төгөлдөр Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтад үндэслэн, шүүх нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгсэхгүй болгосон шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг хүчингүй болгодог туршлага, эрх зүйн шинжлэх ухааны ойлголт, практик байхгүй байна.

өмнө эрх тэгш байна”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ...хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул уг хуулийг баталсан өдрөөс хүчингүй болгосугай” гэж эцэслэн шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, тус хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийг сэргээн шалгахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн хэмээн үзэж хүчингүй болгон шийдвэрлэжээ.

### Хүчиндэх гэмт хэрэг

Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг бусад улс орон зарим төрлийн гэмт хэргээс ялгамжтай байдлаар тогтоодог. Тухайлбал, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78b-ийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн 174-174с, 176-178, 180 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 182, 225, 226а болон 237 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдийн хувьд хохирогч 30 нас хүрвэл” хөөн хэлэлцэх хугацаа зогсохоор хуульчилжээ.<sup>97</sup> Энэ зүйл хэсэгт дурдсан тус хуулийн 174-184 дэх хэсэг нь бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд бөгөөд 176 дахь хэсэг нь хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үзүүлэхтэй холбоотой гэмт хэрэг юм.

Манай улсын хувьд 2015 оны Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд хүчиндэх гэмт хэргийг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих хүртэл ялтай учраас гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй.

Харин 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх үед бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа 25 жил байсан. Тус гэмт

<sup>97</sup> Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо нар (2021), Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль, 391 дэх тал.

хэргийн улмаас хохирсон хохирогч 25 жилийн дараа цагдаагийн байгууллагад гомдол гаргасан ч гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн тохиолдол гарч байсан билээ. Хэргийн талаар товчхон дурдвал:

*Тохиолдол<sup>98</sup>*

Хэрэг үйлдэгдсэн газар: Баян-Өлгий аймаг

Эрүүгийн хэргийн дугаар: 181300036

Хэргийн товч утга: “С” нь 1992 оны 8 дугаар сарын 20-ны өдөр нагац эгчийнхээ есөн настай охин “Ө”-г хүчиндсэн гэмт хэрэгт холбогджээ.

Прокурорын тогтоол: Хохирогч “Ө”-г 1992 онд буюу түүнийг есөн настай байхад нагац ах “С” хүчиндсэн нь тогтоогдоогүй, уг үйлдэлд гэмт хэргийн шинжгүй гэж үзэн хэргийг хааж шийдвэрлэсэн.

Хохирогч “Ө” мэдүүлэхдээ “...Одоогоос 25 жилийн өмнө буюу 1992 оны 8 дугаар сарын 20-ны үеэр ээжийн төрсөн дүү болох манай нагац ахын хүүхэд буюу миний үеэл “С” гэх залуу Бүгд Найрамдах Казахстан Улсад сургуульд сурахаар болж Баяннуур сумаас Өлгийд ирж манай гэрт хоносон. Маргааш өглөө нь аав, ээж хоёр ажилдаа, ах хичээлдээ явсны дараа гэрийн хаалга дотроос нь түгжээд, намайг хүчиндсэн. Хүчиндүүлснээсээ хойш би сэтгэл санааны дарамтад орж, айж, тухайн үед болсон асуудлын талаар хэнд ч хэлэлгүй өнөөдрийг хүртэл явсаар ирсэн. Намайг хүчиндсэнийхээ дараа үеэл ах “С” Казахстан Улс руу сургуульд сурахаар явсан” гэж мэдүүлдэг.

Хохирогч 25 жилийн дараа яагаад гомдол гаргасан учраа тайлбарлахдаа:

<sup>98</sup> Монгол Улсын хэмжээнд 2012-2016 онд үйлдэгдсэн “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсан суурь судалгаа” (2018), УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэн.



“Би 2007 онд “Б.С” гэх залуутай гэр бүл болоод бэлгийн харьцаанд ортол “Чи онгон биш байна, өмнө нь өөр хүнтэй бэлгийн харьцаанд орж байсан юм уу?” гэхээр нь би болсон хэргийн талаар хэлтэл намайг хаяад яваад өгсөн. Тухайн үед би жирэмсэн байсан. Нөхрөөсөө салсан болохоор ээж, аавтайгаа хамт амьдарч байгаад хүүхдээ төрүүлсэн. Ээж, аав хоёр эцэггүй хүүхэд төрүүлж, нутаг усанд гэр бүлийнхээ нэр төрийг гутааж байна гэж үргэлж загнадаг болсон. Би энэ байдлыг тэсэлгүй амиа хорлох талаар бодож явсан үе ч надад бий. Тухайн үед манай дүү өвчний улмаас нас барж эцэг эх маань ихэд гашуудаж, сэтгэл санаагаар унасан байсан учир би амиа хорлож чадаагүй.

Гэсэн хэдий ч ах дүү, хамаатан садан, айл хөрш, нутаг усныхан маань намайг эцэггүй хүүхэд төрүүлсэн хэмээн байнга муу муухайгаар ярьдгаас манай гэрт байнгын хэрүүл маргаантай байдаг байсан. Аав, ээж маань бүх зүйл чамаас болж байна хэмээн 10 жилийн турш намайг буруутгаж ирсэн. 2014 онд аав маань Баян-Өлгий аймагт бидэн шиг зовж зүдэрч байгаа хүн алга, ингэж нутаг усныхныхаа доог тохуу болж амьдарч чадахгүй гээд голын усанд живэн амиа хорлон нас барсан.

Гэтэл би хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон хэр нь насаараа энэ муухай хэргийн улмаас амьдын тамд амьдарсаар өнөөдрийг хүрсэн. Үеэл ах “С” миний амьдралыг үгүй хийснийг би одоо л ойлгож байна. Өнөөдрийг хүртэл би үхсэн хүнтэй л адилхан амьдарч ирсэн, амьдрах хүсэл, амьдралд итгэх итгэл алдарч байна. “С” тухайн үед намайг хүчиндээгүй байсан бол би өнөөдөр нөхөр, үр хүүхэд, эцэг эхтэйгээ сайхан амьдарч байх байсан. Миний 25 жилийн амьдралыг үгүй хийсэн учир үнэхээр их гомдолтой байна.

Одоо ч сэтгэлийн шаналлаас болж унтаж чадахгүй, зүрхний өвчтэй, ухаан алдаж, татаж унадаг өвчтэй болсон” гэх мэдүүлгээс хүчиндэх гэмт хэргийн хор уршиг, хохирол олон жилийн дараа ч байсаар байдгийг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, тухайн гэмт хэргийн хохирол, хор уршиг 25 жилийн дараа ч байсаар байна. Энэ мэтчилэн Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэрэгт нийгмийн хор аюулын хэмжээ, учруулж буй хохирол, хор уршиг зэргээс шалтгаалан бусад гэмт хэргээс ялгамжтай байдлаар тогтоох шаардлагатай байдаг.

Дээрхээс гадна манай улсын шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хүнийг алах (ЭХ-ийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг), бэлгийн мөлжлөг (ЭХ-ийн 12.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг) гэх мэт хэрэгт бүх насаар хорих ял оногдуулахаар заасан учир гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар зохицуулсан. Үүний нэгэн адил дэлхийн зарим улс оронд дээр дурдсан эрүүгийн хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолдоггүй. Тухайлбал, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2-т “Энэ зүйлийн 211 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн (хүний амь нас хөнөөх) хувьд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй” гэж заасан.<sup>99</sup>

Түүнчлэн манай улсын Эрүүгийн хуулийн 19 дүгээр бүлэг буюу “Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” бүлэгт заасан гэмт хэргүүдтэй зарим талаар ойролцоо утга агуулга бүхий хэргүүдэд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар зохицуулсан улс орнууд ч цөөнгүй байна.<sup>100</sup>

Олон улсын гэрээ хийгээд дэлхийн зарим улс орны хууль тогтоомжид манай улстай ижил байдлаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар хуульчилсан тохиолдол цөөнгүй байна. Энэ нь тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ, учруулсан хохирол, хор уршиг зэрэгтэй шууд хамааралтай гэж үзэж болох юм.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илрүүлэхэд төвөгтэй, цаг хугацаа их шаарддаг зарим төрлийн гэмт хэрэг, тэр дундаа нуугдмал гэмт хэргүүдийн хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа бусад хэргээс илүү уртаар тоологдох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ийм хэргүүд зохион байгуулалттай, илрүүлэхэд хүндрэлтэй, маш олон шат

<sup>99</sup> Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо нар (2021), Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль, 391 дэх тал.

<sup>100</sup> Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 12 дахь хэсэг, 34 дүгээр бүлэгт энх тайван ба хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг хуульчилсан бөгөөд энд дурдсан зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй гэж заасан байдаг.

дамжлага дамжсан байхын зэрэгцээ нуутгдмал байдлаар үйлдэгддэг зэргээс шалтгаалан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаан явагддаг. Нөгөөтээгүүр өөр гэмт хэрэг илрүүлсний үр дүнд тухайн гэмт хэргийн сэжүүр олдож, илрүүлэх тохиолдол ч байдаг. Энэ мэтчилэн маш олон шалтгаан, нөхцөлөөс хамааран зарим төрлийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэргээс ялгамжтай байдлаар авч үзэх зайлшгүй шаардлага тулгардаг.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Бүлгийн хүрээнд авч үзсэн олон улсын баримт бичгийн агуулгыг Монгол Улс дотоодын хууль тогтоомждоо зохих байдлаар нийцүүлэн хуульчилсан нь харагдаж байна. Тухайлбал, манай улсын хувьд бага насны хүүхдийг хүчиндэх, мансууруулах бодистой холбоотой зарим хэрэгт бүх насаар нь хорих ял оногдуулахаар шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан учир эдгээр хэрэгт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохооргүй байгаа нь олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенцын заалтыг дотоодын хууль тогтоомждоо бүрэн утгаар нь тусгасан гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, олон улсын гэрээ конвенцоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргүүд нь зөвхөн тухайн улс орны бус олон улсын, үндэстэн дамнасан гэмт хэргийн шинжийг давхар агуулж мөнгө угаах, хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэх мэт олон гэмт хэргийн үндэс суурь болдгийн хувьд тухайн гэмт хэрэгт оногдуулах ял, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг зарим төрлийн гэмт хэргээс уртаар тогтоох нь зүйтэй гэсэн зохицуулалттай нийцэж байгаа юм. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч гэмт хэрэг үйлдэгдэх үед 14 насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй, гэмт хэргийн хохирогч болсноо илэрхийлэх чадваргүй, болсон үйл явдлын талаар хэнд хэлэх, хаана хандахаа мэдэхгүй, бие даан шийдвэр гаргах боломжгүй зэрэг маш олон шалтгаан, нөхцөл нөлөөлж байдаг. Иймээс ч энэ төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоох нь зүйтэй бөгөөд манай Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байх зохицуулалттай байна.

Харин авлигын гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, гэмт хэргийг илрүүлэхэд шаардах хугацаа, учруулж буй хохирол, нийгмийн хор аюулын хэмжээ, онцлог, шинж, олон улсын туршлага зэргийг судлан үзэж, өөрийн орны онцлог шинжид тохируулан боломжит байдлаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг уртасган Эрүүгийн хуульд тусгах нь зүйтэй харагдаж байна. Учир нь авлигын хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль нь Үндсэн хуульд нийцээгүй, хүний эрхийг ноцтой зөрчсөн зэрэг үндэслэлээр Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн шийдвэрлүүлээд байна. Энэ хууль нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх асуудлын хүрээнд Монгол Улсын түүхэнд урьд хожид байгаагүй асуудлыг хөндсөн буюу Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх, тэр дундаа эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй гэсэн зарчмын заалтыг үгүйсгэн хуульчлагдсан нь асуудал дагуулаад байсан юм. Хэдийгээр одоо уг хуулийг бүхэлд нь хүчингүй болгосон шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргаж, асуудал нэг талдаа гарч байгаа хэдий ч хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс Цэцийн шийдвэр гарсан өдөр хүртэл уг хуулийн дагуу сэргээн шалгаж байсан хэргүүдийг буцаан 2015 оны Эрүүгийн хуулийн дагуу шийдвэрийг өөрчлөх асуудал яригдахаар байна. Мөн уг хуулийн үйлчлэлээс шалтгаалан хохирсон иргэдийн нөхөн төлбөрийн асуудал ч яригдах үндэслэлтэй болж байгаагаас гадна ажиллагаа хийж байсан прокурор, шүүгчдийг ч эргэж буцсан олон ажил хийлгэсэн эрүүгийн эрх зүйн түүхэнд байгаагүй онцлог кейс үүсээд байгаа билээ.

Нөгөөтээгүүр авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа харьцангуй багаар хуульчлагдсан нь тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байж болзошгүй юм. Учир нь авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа богино байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн хүн эрүүгийн хариуцлагаас хуулийн дагуу мултрах, ял завших боломж олгож буй гол үндэслэл болохын сацуу хууль тогтоогчид авлигын гэмт хэрэгт ял оногдуулахын тулд Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй хууль тогтоомжийг батлан гаргах үндэс суурь болсон гэж үзэж болох юм.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан тодорхой хугацааны дотор эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол дараа дахин тэр хэрэгт нь хариуцлага хүлээлгэх нь үр дүнгүй байдаг бөгөөд энэ нь юуны өмнө өнгөрсөн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээд засарч хүмүүжсэн байж болох талтайгаас гадна үйлдэгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсний дараа илэрч байгаа гэмт хэргийн нотлох баримтууд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байх, хэргийн бодит үнэнийг тогтооход хүндрэл учрах, үүнээс үүдэн шүүгдэгчийн эрх ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй зэргийг харгалзан үзэж хөөн хэлэлцэх хугацааг хуульчлах зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэдэг бол нэг талаас тухайн хэрэгт хяналт тавьж байгаа субъектүүд ЭХХШтХ-ийн дагуу тухайн хэргийг түргэн шуурхай илрүүлж зохих ял шийтгэлийг нь оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял завшуулахгүй байх үүрэг хүлээлгэж буй зохицуулалт, нөгөө талаас эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг удирдлага болгож гэмт хэрэг үйлдсэн этгээдийг чөлөөлөх үндэслэл болдог учир гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь ихээхэн ач холбогдолтой зохицуулалт юм.

Хөөн хэлэлцэх хугацааны түүхэн уламжлалыг судлан үзэхэд шинэ үеийн төрөлжсөн хууль болох 1926, 1929, 1934 оны Шүүхийн цаазын бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуульд тусгагдан зохицуулагдаж иржээ. 1926, 1929 оны Шүүх цаазын бичигт хөөн хэлэлцэх хугацааны нэг төрлийг л хуульчилж өгсөн бол 1934 оны Шүүхийн цаазын бичигт таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол биелүүлж болохгүй хугацааны талаар анх удаа оруулж гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулж болох ялын байдалтай нь харьцуулан 3-10 жил байхаар нарийвчлан тогтоож байсан байна. Тэгвэл 1942 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар бэхжүүлсэн заалт нь 1934 оны Шүүх цаазын бичгийн заалттай харьцуулахад зарчмын ялгаа байхгүй ба

хувьсгалын эсэргүү гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхийг хориглох заалтыг шинээр нэмж оруулжээ.

Харин 1961 оны Эрүүгийн хуулиар мөрдөн шалгах явцад оргон зайлсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тоолох уу эсхүл зогсоох уу гэсэн зохицуулалтыг хуульчилж өгсөн бөгөөд 1942 оны Эрүүгийн хуулиар хувьсгалын эсэргүү гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэггүй байсан бол 1961 оны хуулиар тодорхой төрлийн хэрэгт биш, зөвхөн цаазаар авах ял оногдуулж болохоос бусад бүх хэрэгт хэрэглэхээр заасан байна. 1986 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар бэхжүүлсэн заалт нь 1961 оны Эрүүгийн хуулиас онцын ялгагдах зүйлгүй бөгөөд хугацааны интервалын хувьд бага зэрэг өссөн, буурсан байдлаар хуульчлагджээ. 2002 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийн ангиллаас хамаарч хөөн хэлэлцэх хугацаа буюу эрүүгийн хариуцлагад татах хугацаа, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэх хугацааг хэрэглэхээр зохицуулснаараа онцлог байсан бол 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамаарч тоолдог байсныг өөрчилж оногдуулж буй ялын дээд, доод хэмжээнээс хамаарч тоолохоор хуульчилжээ. Ингэхдээ зөвхөн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэргүүдэд л хөөн хэлэлцэх хугацааг тоолох боломжтой байсан бөгөөд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж торгох ял оногдуулахаар заасан буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор болсон.

Судалгааны хүрээнд гадаадын зарим орны хууль тогтоомж дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг өөрийн орны зохицуулалттай харьцуулан үзэхэд ХБНГУ 3-30 жил, БНСУ 1-30 жил, БНХАУ 5-20 жил, ОХУ 2-15 жилээр гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон бол манай шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд 1-20 жил байхаар хуульчилснаас харахад дундаж хугацаанд хамаарч байна. Түүнчлэн ХБНГУ болон БНХАУ-ын хувьд бүх насаар хорих ял шийтгэсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор, БНСУ-ын хувьд ялын бүх төрөлд хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор, ОХУ-ын хувьд гэмт хэргийн ангиллаас хамаарч хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчилсан нь манай Эрүүгийн хуулийн зохицуулалтаас ялгаатай байгаа бол ХБНГУ, БНСУ, БНХАУ-ын хувьд ялын дээд,

доод хэмжээнээс хамааруулан хөөн хэлэлцэх хугацааг тооцохоор хуульчилсан нь манай зохицуулалттай ижил байна. Түүнчлэн ОХУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг “...гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө хугацаагаар тоолно. Тухайн этгээд дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолно”<sup>101</sup> гэж заасан нь манай 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалттай ижил байна. Харин БНХАУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг “Нэхэмжлэн заалдах хугацааг ял хийсэн өдрөөс нь эхэлж бодно; ялт ажиллагаа нь залгалдсан буюу үргэлжилсэн байдалтай байвал ялт ажиллагааны дууссан өдрөөс эхэлж бодно, нэхэмжлэн заалдах хугацааны дотор дахиж ял хийсэн байвал өмнөх ялын нэхэмжлэн заалдах хугацааг хойнох ялыг хийсэн өдрөөс эхэлж бодно”<sup>102</sup> гэж, ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг “Гэмт хэрэг төгссөнөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно. Хэрэв гэмт хэргийн бүрэлдэхүүн болж буй үр дүн хожим бий болсон бол тэр үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно”<sup>103</sup> гэж тус тус заажээ. Мөн эдгээр улсын хуульд хөөн хэлэлцэх хугацаа зогсох, тасрах тухай нарийвчлан хуульчилсан байна.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нэг үндэслэл болсон гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тусгасан 2015 оны Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээг практикт нэг мөр ойлгож хэрэглэх явдал учир дутагдалтай, зарим гэмт хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагдсан нь уг хуулийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн хүндрэлтэй байдал үүсгэж байсан билээ. Өөрөөр хэлбэл, энэ нь ял завшуулах, хүний эрхийг зөрчихөд хүргэж байсан юм.

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг зохицуулалтад тодорхой өөрчлөлт оруулсан нь зарим талаар энэхүү зохицуулалтыг практикт хэрэглэхэд үүсэж байсан хүндрэлийг шийдвэрлэсэн юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...гэмт хэрэг үйлдсэн

<sup>101</sup> Ж.Эрдэнэбулган нар, Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль, УБ., 2021, 124 дэх тал. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<sup>102</sup> Мөн тэнд, 276 дахь тал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйл.

<sup>103</sup> Мөн тэнд, 391-392 дахь тал, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78а.



өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж заасныг тус хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй уялдуулан “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэж өөрчлөн найруулсан нь тус зохицуулалтын эрх зүйн хийдлийг арилгаж, уялдаа холбоо хангасан өөрчлөлт болсон. Өөрөөр хэлбэл, манай орны хувьд ЭХХШтХ-ийн зарим зохицуулалт эрх зүйн хийдэлтэй, практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хуулийг нэг мөр тайлбарлаж хэрэглэж чадахгүй байгаагаас шалтгаалан анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь гэмт хэрэг үйлдсэн хүн (тэдгээрийн өмгөөлөгч) эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, өмгөөлөгчид хүндэтгэн үзэх шалтгаан дурдаж шүүх хуралдааныг хойшлуулах, үндэслэлгүй хүсэлт, гомдол олонтаа гаргах, үндэслэлгүйгээр шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, хэргийг буцаах гэх мэтээр сунжруулж, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгуулах эрсдэл үүсгэж байсан. Иймд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолохоор зохицуулсан нь одоогийн нөхцөлд хамгийн тохиромжтой зохицуулалт юм. Гэсэн хэдий ч яллагдагчаар татах хүртэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох нь огт алдаа мадаггүй зохицуулалт биш гэдгийг анхааран үзэх нь зүйтэй. Учир нь тухайн гэмт хэрэгт яллагдагчаар татагдсанаас хойш эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжирч, удаан хугацаагаар үргэлжлэх, гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулах, зарим эрхийг хязгаарлах ажиллагаа болохыг үгүйсгэхгүй юм. Энэ тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй субъектүүд хуульд заасан үйл ажиллагааг хурдан шуурхай явуулах, тухайн хүнийг хохироохгүй байхад анхааран ажиллах шаардлагатай.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл эсхүл анхан шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл тоолох асуудлын хувьд аль аль нь сул талтай ч практикт хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтойг нь сонгон хуульчлах нь зүйтэй юм. Дээр дурдсанчлан, манай улсын хувьд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолох нь илүү тохиромжтой гэж үзэж байна.



Мөн Эрүүгийн хуульд 1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг нэмж хуульчилсан нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэг эсхүл таван жилийн хугацаагаар тоолохоор хуульчлагдсан заалтад аль алинд нь хамаарч байсан нийт 53 заалтаас 50 заалтад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гурван жилээр тоолох боломж бүрдүүлсэн. Нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дээрх дэвшилттэй зохицуулалт тусгагдсан хэдий ч зарим ойлгомжгүй, эргэлзээ үүсгээд байсан зохицуулалтыг засаж, сайжруулж чадаагүй гэж үзэж болохоор байна. Тухайлбал, дээр дурдсан 53 заалтаас гурван заалтын тухайд (Эрүүгийн хуулийн 17.1.1, 17.2.1, 17.12.1) гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэг эсхүл таван жилийн алинаар тооцох нь тодорхойгүй байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн торгох ял оногдуулахаар заасан буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар зохицуулалтгүй байсныг засаж сайжруулахыг зорьсон боловч тус зохицуулалт нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар эргэлзээтэй байдал бий болгосон хэвээр байна.

Мөн зарим тодорхой төрлийн гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг бусад хэргээс ялгамжтай байдлаар тооцох зохицуулалт шаардлагатай байгаа нь 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн маргаан дагуулсан асуудлаас тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн хор аюулын хэмжээ, учруулж буй хохирол, хор уршиг ихтэй гэмт хэргийн (тухайлбал, авлигын гэмт хэргийн) хөөн хэлэлцэх хугацааг уртасгах зайлшгүй шаардлага үүссэн байна.

Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг хэдийгээр сайжруулан засаж нэмэлт, өөрчлөлт оруулсан ч цаашид засаж сайжруулбал зохих асуудал байсаар байгааг анхааран үзэж, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх Эрүүгийн хууль дахь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон, зөв голдиролд оруулах нь зүйтэй. Үүний тулд судалгааны ажлын үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт

хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Хууль батлахдаа судалгаатай хандах, ялангуяа хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан судалгаа, тоо баримтад үндэслэх, эрсдэл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг бүх талаас нь урьдчилан тооцоолж байх;
- 2015 онд өргөн баригдсан хуулийн төслийн хувьд гэмт хэргийн ялын доод хэмжээг тогтоолгүйгээр дээд хэмжээнээс хамааруулан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор хуульчилсан байсан нь эрх зүйн хэм хэмжээний хийдлийг арилгах нэг гарц байж болох юм;
- Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.2.1, 17.12.1-д заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцохыг нэг мөр болгох;
- Торгох ял оногдуулахаар заасан хэргүүдэд ялын хэмжээнээс хамааруулан хөөн хэлэлцэх хугацаа тоолдог байхаар хуульчлах. Өөрөөр хэлбэл, торгох ял оногдуулахаар заасан заалтуудад торгох ялын доод хэмжээг 10,000, дээд хэмжээг 400,000 хүртэл байхаар хуульчилсан байх тул хөөн хэлэлцэх хугацааг торгох ялын хэмжээнээс хамааруулан ялгамжтай тоолохоор хуульчлах. Тухайлбал, 10,000-100,000 нэгжтэй тэнцэх, 20,000-200,000 нэгжтэй тэнцэх, 120,000-400,000 нэгжтэй тэнцэх гэх мэтээр ялгамжтай байдлаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тоолох талаар зохицуулах;
- Нийгмийн хор аюулын хэмжээ, учруулж буй хохирол, хор уршиг зэргээс шалтгаалан Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай байдлаар хуульчлах. Тухайлбал, авлигын гэмт хэргийг илрүүлэхэд төвөгтэй байдлыг харгалзан үзэж хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх.
- Нэр томъёог нэг мөр болгох (гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа).

# НОМ ЗҮЙ

## Хэвлэмэл эх сурвалж:

### Нэг. Хууль тогтоомж

1. Захиргааны ерөнхий хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, №28.
2. Иргэний хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, №78.
3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1997, №6.
4. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1926.
5. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1929.
6. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг, 1934.
7. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1942.
8. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1961.
9. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1986.
10. Эрүүгийн хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2002, №5.
11. Эрүүгийн хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2016, №7.
12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017, №23.

### Хоёр. Ном, гарын авлага

1. Ж.Амарсанаа, О.Батсайхан, Монгол Улсын Үндсэн хууль: Баримт бичиг (1924, 1940, 1960, 1992), УБ., 2004.
2. Ж.Амарсанаа нар, Хууль зүйн тайлбар толь, УБ., 2003.
3. Б.Баярсайхан нар, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), УБ., 2011.
4. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2011.
5. Г.Гантөмөр, О.Амарсайхан, Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, УБ., 2004.

6. Э.Зууннасан, Б.Батзориг, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль, УБ., 2006.
7. С.Жанцан, Гэмт хэргийн олонлог, УБ., 1990.
8. С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүй-альбом-схем, УБ., 1991.
9. С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, ерөнхий анги, УБ., 1997.
10. С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй, УБ., 1999.
11. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, УБ., 2015.
12. Г.Совд, БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс, УБ., 1973.
13. Г.Совд, Эрүүгийн хариуцлага: уламжлал, шинэчлэлийн асуудал, хууль зүйн докторын зэрэг горилж бичсэн бүтээл, УБ., 1992.
14. Г.Совд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2005.
15. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, УБ., 1966.
16. Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн удиртгал, УБ., 2004.
17. Ж.Эрдэнэбулган, Т.Золбоо нар, Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль, УБ., 2021.

Гурав. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл

1. Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудал хүний эрхийг зөрчих нь, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019, №1.
2. Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2020, №2.

Дөрөв. Судалгаа, тайлан

1. Улсын Ерөнхий прокурорын 2012-2021 оны 5 дугаар сар дуусталх тайлан мэдээ.
2. Монгол Улсын хэмжээнд 2012-2016 онд үйлдэгдсэн “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсан суурь судалгаа”, УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэн, УБ., 2018.

## Цахим эх сурвалж

Нэг. Олон улсын гэрээ, хууль тогтоомж

1. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм.  
<https://legalinfo.mn/law/details/1217?lawid=1217&sword>
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц.  
[https://www.legalinfo.mn/law/?cat=29&l\\_name=%D0%9C](https://www.legalinfo.mn/law/?cat=29&l_name=%D0%9C)
3. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц.  
<https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>
4. German Criminal Code.  
[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html)
5. Criminal Law of the People's Republic of China.  
<https://www.fmprc.gov.cn/ce/cgvienna/eng/dbtyw/jdwt/crimelaw/t209043.htm>
6. Уголовный кодекс Российской Федерации.  
[http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_10699/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/)
7. Criminal code.  
<https://www.refworld.org/pd/fid/3f49e3ed4.pdf?fbclid=IwAR18CNwc-G9McbRkQDE4FNcDdauNEd5mILyWy8Wsg3XtNL75nNoAvpXskYs>
8. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №12 тогтоол.  
<https://www.legalinfo.mn/law/details/15812?lawid=15812>
9. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №01 тогтоол.  
<https://www.legalinfo.mn/law/details/16628?lawid=16628>
10. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр.  
<https://www.legalinfo.mn/annex/details/5591?lawid=8722>

Хоёр. Ярилцлага

1. Д.Зүмбэрэлхам, Хөөн хэлэлцэх хугацаа ба ял завшуулах ажиллагаа, ярилцлага (2019).  
<http://itoim.mn/article/iLAEP/17846?fbclid=IwAR0fXy8X4kG6TxaOwKyEmOtUwEy0r983idkVaDyvtzhdiCcl5L5Aj76pY8>

2. Х.Эрдэм-Ундрах, 84 гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь тодорхойгүй байна, ярилцлага (2019).  
<https://newspress.mn/v1/p/news/10206>

Гурав. Бусад

1. Монгол Улсын нэгдэж орсон олон талт гэрээ, конвенц.  
<http://vienna.embassy.mn/index.php?moduls=15>
2. Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.  
<http://parliament.mn/n/cy8o>
3. Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.  
<http://parliament.mn/n/oumy>
4. Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (2020.01.08, Лхагва гараг).  
<http://parliament.mn/n/8umy>
5. Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (2019.12.12, Пүрэв гараг).  
<http://parliament.mn/n/3uko>
6. Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (2019.12.11, Лхагва гараг).  
<http://parliament.mn/n/3mko>
7. Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (2015.12.01, Мягмар гараг).  
<http://parliament.mn/n/uwey>
8. Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (2015.07.07, Мягмар гараг).  
<http://parliament.mn/n/jo8o>
9. Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл (2015.06.16, Мягмар гараг).  
<http://parliament.mn/n/qw8y>
10. Шүүхийн шийдвэрийн цахим сан.  
<http://new.shuukh.mn/eruanhan/27256/view>

Хавсралт

| № | 2015 оны<br>Эрүүгийн хуулийн<br>зохицуулалт                                                                                                       |  | 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар<br>нэмэлт, өөрчлөлт орсон байдал                                                                                                                                                                                                                                                                                            |  | Харьцуулалт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |  |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|   |                                                                                                                                                   |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |  |
| 1 | -                                                                                                                                                 |  | <b>1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалт.</b><br>Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн. |  | <b>Шинээр нэмж хуульчилсан.</b><br>Энэхүү заалтыг нэмж хуульчилснаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг нэг эсхүл таван жилийн хугацаагаар тоолохоор хуульчлагдсан заалтад аль алинд нь хамаарч байсан нийт 53 заалтаас 50 заалтад гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гурван жилээр тоолох боломж бүрдүүлсэн.                                                                                               |  |
| 2 | <b>1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.</b><br>Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно. |  | <b>1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.</b><br>Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно.                                                                                                                                                                                                                 |  | <b>Өөрчлөлт оруулсан.</b><br><b>Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.</b><br>“Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” <sup>105</sup> гэж заасан нь Эрүүгийн хуулийн тус зохицуулалт нь мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан заалтууд өөр хоорондоо зөрүүтэй байсныг нэр мөр болгосон. |  |

<sup>104</sup> 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн гэмт хэрэг хянан шийдвэртэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Гэмт хэрэг хянан шийдвэртэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно” гэж хуульчилсан байсныг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

|   |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|---|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 3 | - | <p><b>1.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.</b><br/>Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна.</p>                                                                                                                                                                                  | <p><b>Шинээр нэмж хуульчилсан.</b><br/>Энэхүү заалтыг нэмж хуульчилснаар татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нэг жилийн хөөн хэлэлцэх хугацаатай байсныг таван жил болгосон. Мөн энэхүү зохицуулалт нь (18.3 дугаар зүйл) Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдээс ганцаараа хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан хуульчилсан зохицуулалт болсон юм.</p> |
| 4 | - | <p><b>1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.</b><br/>Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.</p> | <p><b>Шинээр нэмж хуульчилсан.</b><br/>Энэхүү зохицуулалтыг нэмж хуульчилснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломж бүрдсэн.</p>                                                                                                                                                              |



ГЭМТ ХЭРГИЙГ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

ISBN 978-9919-9812-3-5



9 789919 981235